# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Эдийн засаг, хөгжлийн яам

## 2022 оны жилийн эцэс

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | 1 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн А/27 тоот тушаалаар ”Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, “Албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийг тус тус баталсан. Дараах арга хэмжээг авч ажилласан. 2022 онд албан хаагчдыг дараах сургалтад хамруулсан. - Удирдлагын академийн Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч, Дунд хугацааны мэргэшүүлэх давтан сургалтад 3 албан хаагч, Дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагч, Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт /зайн сургалт/ 7 албан хаагч, Төрийн албан хаагчийг зорилтод богино хугацааны сургалт /зайн сургалт/ - 4 албан хаагч. - Авлигатай тэмцэх газрын авлигын эсрэг үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан Удирдах албан тушаалтанд зориулсан -1, ЭБАТ-д зориулсан 1 албан хаагч. - Жендерийн сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтад 2 албан хаагч. - Цогц чадамжид суурилсан албан тушаалын тодорхойлолт | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | боловсруулах арга зүйн сургалтад -10, -Төрийн худалдан авах А3 сертификат сургалтад 10 албан хаагч, Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад 1 албан хаагч, -Дэлхийн банкны төслийн санхүүжилтээр Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтод хөтөлбөрийн төслийн танилцуулга семинарт нийт албан хаагчдыг 2022 оны 6 дугаар сарын 10-нд /83 албан хаагч/ хамруулсан. | | | |
| 2 | 2 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01 | 21.5. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д тусгагдсаны дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2021 оны явцын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 2/35 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тайланг Засгийн газрын хуралдаанаар танилцуулж, УИХ-ын байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэн, 2022 оны 3 дугаар сарын 31-нд УИХ-д танилцуулсан. | 100% | 100% | Хэрэгжилт тогтмолжсон тул дотоод хяналтадаа авч ЗГХШҮМС-ийн хяналтаас хасуулах |
| 3 | 3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 75 дугаар тогтоолоор “Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар”-ыг баталсан. Тус хөтөлбөрийн 2.1-т “Үйл ажиллагааны стратегийн мөн чанар”, 2.2-т “Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл”, 2.3-т “Эрхэм зорилго”, 2.4-т “Стратегийн зорилт” болон эдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх гол зорилтуудыг тодорхойлсон. Үйл | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагааны стратегийн хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-46 дугаар тушаалаар Эдийн засаг, хөгжлийн яамны 2022-2024 онд хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөөг баталж, түүнд арга хэмжээ тус бүрийг хүрэх үр дүнгийн хамт тодорхойлсон. /Эдийн засаг, хөгжлийн яам (med.gov.mn) | | | |
| | 4 | | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Эдийн засаг, хөгжлийн яамны зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийн талаарх мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн яам (med.gov.mn) цахим хуудсанд нээлттэй байршуулсан болно | 100% | 100% | |
| | 5 | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны 1-4 сарын мэдээлэл оруулсан байдалд явцын хяналт хийсэн. Нийт 48 мэдээллийг тайлагнахаас 75 хувийг хугацаанд нь, 25 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Илэрсэн асуудлуудыг танилцуулгад тусган удирдлагад танилцуулсан. | 100% | 100% | |
| | 6 | | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эхний хагас жилийн тайланг 7 дугаар сарын 10-н ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2022 оны 10 дугаар сараас сар тутмын тайланг www.new.unelgee.gov.mn цахим мэдээллийн санд оруулж баталгаажуулсан. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 7 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2021 оны явцын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2022.02.25-ны өдрийн 10/104 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Нийт 21 аймаг, нийслэлийн хэмжээнд 3100 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээс 1259 арга хэмжээ үр дүнтэй, 1009 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 263 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 569 арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдсэн. Аймаг тус бүрээр үнэлгээг гаргахад нийт дүнгээр 15 аймаг болон нийслэл тодорхой үр дүнд хүрсэн гэж үнэлэгдсэн бөгөөд Дархан-Уул аймаг 90.8 хувь, Хэнтий аймаг 90 хувийн үнэлгээтэй гарч, 2021 оны хэрэгжилтээр хамгийн өндөр үнэлгээтэй гарсан. Харин Архангай аймаг 63.1 хувь, Дорнод аймаг 62.3 хувь, Дундговь аймаг 61.2 хувь, Сүхбаатар аймаг 59.2 хувь, Баянхонгор аймаг 56.1 хувь, Орхон аймаг 44.5 хувийн биелэлттэй үнэлэгдэж, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна. Аймаг, нийслэлийн таван жилийн үндсэн чиглэлд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд нийт 18 аймаг, нийслэлийн хэмжээнд 4.1 их наяд төгрөгийн төсвийг зарцуулахаар төсөвлөж, гүйцэтгэлээр 1.6 их наяд төгрөгийг зарцуулсан байна. | 100% | 100% | |
| | 8 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүргийн хүрээнд салбарын хэмжээнд хэрэгжүүлэх 10 хууль, нийтлэг мөрдөх 10 хууль, бодлогын баримт бичгүүд болон холбогдох хууль тогтоомжийг Эдийн засаг, хөгжлийн яам (med.gov.mn) цахим хуудсанд нээлттэй байршуулсан болно. | 100% | 100% | |
| | 9 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан | Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-д нийцүүлэн тус яамны төрийн захиргааны удирдах албан тушаалын тодорхойлолт 18, гүйцэтгэх /ахлах түшмэл, дэс түшмэлийн/ албан тушаалын тодорхойлолт 60, төрийн үйлчилгээний 5 нийт 83 албан тушаалын тодорхойлолтын төслийг тус тус боловсруулан батлах зөвшөөрөл авахаар Төрийн албаны албаны зөвлөлд 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 03/510 дугаартай албан тоотоор хүргүүлсэн. Албан хаагчдын нэр, албан тушаал, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийн жагсаалтыг байгууллагын Эдийн засаг, хөгжлийн яам (med.gov.mn) цахим хуудсанд нээлттэй байршуулсан болно. | | | |
| | 10 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 109 өргөдөл, гомдлыг хүлээн авсан бөгөөд шийдвэрлэлт 95.4 хувьтай байна. Ажилд орох болон чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдлүүдийн 54.5 хувийг эзэлж байна. Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд түргэн, шуурхай шийдвэрлэхэд анхааран ажилласан. | 100% | 100% | |
| | 11 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Хөрөнгө оруулалтын холбогдолтой статистик, мэдээллийн хувьд Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газарт албан бичиг хүргүүлсэн ба ирсэн тайлангуудыг нэгтгэх ажил хийгдэж байна. Гадаад худалдааны статистик мэдээг Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т заасны дагуу Гаалийн ерөнхий газарт гаргаж хүргүүлсэн. | 100% | 100% | |
| | 12 | | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | “Монголын худалдаа, хөрөнгө оруулалт, өв соёлын чуулган-Хойд Америк-д” арга хэмжээг 2022 оны 8 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд АНУ Вашингтон хотод зохион байгуулсан. Тус чуулга уулзалтаар | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөрөнгө оруулалтын чуулга уулзалт/бизнес форум, "Монголд үйлдвэрлэв." үзэсгэлэн худалдаа, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулсан. Эдийн засаг, хөгжлийн яам санаачлан МҮХАҮТ-тай хамтран "чөлөөт бүсийн одоогийн хүчин төгөлдөр хууль, эрх зүйн орчныг сайжруулах, цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлоход оролцогч талуудын саналыг тусгах зорилгоор 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр "Чөлөөт бүсийн хөгжлийн бодлого" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт холбогдох төрийн байгууллагууд, чөлөөт бүсийн захирагчийн ажлын албадын төлөөлөл болон хөрөнгө оруулагчид, тээвэр логистикийн салбарын бизнес эрхлэгчид оролцсон. ЭЗХЯ "Монголын Эдийн засгийн чуулган-2022" чуулга уулзалтыг Шинэ Сэргэлтийн бодлогын хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 7-8-ны өдрүүдэд зохион байгуулсан. | | | |
| | 13 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох хүрээнд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам загвар батлах" тухай 17 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, 5 дугаар хавсралтын дагуу гарган холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд яамны https://med.gov.mn/ цахим хуудсандаа тавьж олон нийтэд зарлаж байна. Шилэн дансны тухай хуулийн 6.4.7-т заасан байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээг сар бүрийн 8-ний дотор | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | олон нийтэд мэдээлж ил тод болгон мэдээлж байна. | | | |
| | 14 | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журмыг байгууллагын цахим хуудас https://med.gov.mn/ хүний нөөцийн ил тод үйл ажиллагаа хэсэгт байршуулсан болно. Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд сул орон тооны зарыг байршуулан 18 орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зарлаж 40 хүн бүртгүүлж 26 хүн шалгалтад орсноос 18 иргэн тэнцсэн бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн тушаалаар төрийн албанд жинхлэн томилсон. | 100% | 100% | |
| | 15 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг байгууллагын https://med.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн А/91 тоот тушаалаар Ёс зүйн хороог байгуулан, бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсан. 2022 оны 12 дугаар сарын 25-нд хуралдаж 2023 оны төлөвлөгөөг боловсруулан танилцуулсан. | 100% | 100% | |
| | 16 | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах, тогтвор суурьшилтай ажиллуулж, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх зорилгоор төрийн албаны тухай хууль, хуулийг дагалдуулан гарсан дүрэм, журмын дагуу одоо ажиллаж байгаа албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, сул орон тоог байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас шатлан дэвшүүлэх эсхүл нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас нөхөх, бодлого, чиглэлийг баримтлан ажиллаж байна. Тайлант онд төрийн албаны эрх зүйн шинэ орчны хүрээнд Төрийн албаны тухай | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хуулийн шинэчилсэн хуулийг дагалдуулан гарсан дүрэм журмууд, Төрийн албаны зөвлөлөөс баталсан дүрэм журмууд, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлангийн холбогдох журам болон үнэлэх журмуудыг байгууллагын https://www.med.gov.mn/ цахим хуудсандаа шинэчлэн байршуулсан.  Засгийн газрын мэдээллийн цахим санд www.plan. igovernment.mn нэвтрүүлж албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг цахимаар оруулж Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/141 тоот тушаалаар Үнэлгээний баг байгуулж 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж үнэлгээний баг албан хаагч тус бүрээр үнэлгээг хийсэн. Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 15-ний өдрийн А/27 тоот тушаалаар “Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, сургалтын хөтөлбөр”-ийг  тус тус баталсан. | | | |
| | 17 | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Засгийн газрын тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яам 2022 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр байгуулагдсан. Тус яам нь хүний нөөцийн бодлого, зорилт нь шударга, эрх тэгш, ээрэг таатай орчныг бий болгож байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөнд тулгуурлан байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, судалж сонгох, ажилд томилох, сургаж хөгжүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулах, ажилтнуудын тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор тэдгээрийн албан тушаалыг залгамжлах хүмүүсийг тодорхойлох, албан тушаалд сэлгэн, шилжүүлэн ажиллуулах зэрэг хүний нөөцтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах зохицуулахад оршино. Байгууллагын хүний нөөцийн  бодлого, стратегийн дагуу дараах асуудлуудад төвлөрч ажилласан. Хүний нөөцийн | 100% | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | удирдлагын хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын хүний нөөцийн бодлогын бичиг баримт, төрийн албаны тухай хууль, тогтоомжид нийцүүлэн чадахуйн зарчмыг хэрэгжүүлэх, тухайн албан тушаалд хувь хүний мэдлэг, боловсрол мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлагыг шалгуур болгон түүнийг хамгийн сайн хангаж байгаа хүнийг сонгон шалгаруулж томилох, сонгон шалгаруулах үндсийг тогтоосон албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, зөвшөөрөл авах, батлуулах цаг хугацаа хүчин чармайлт шаардсан томоохон ажлыг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: 1. Албан хаагчийн цалин хөлс, шагнал урамшуулал олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоог бүрдүүлсэн; 2. Байгууллагын бүтэц, орон тоог оновчтой үр ашигтай байх зарчимд нийцүүлэх арга хэмжээ авсан; 3. Төрийн албанд иргэнийг авах, албан тушаал дэвшүүлэх, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, томилох, сургаж хөгжүүлэх бодлого зохицуулалтыг чадахуйн зарчимд нийцүүлэн хэрэгжүүлсэн; 4. Төрийн албан хаагчдыг ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаар хангах хөтөлбөрийг батлуулсан; 5. Ёс зүйн үнэт зүйлсийг хэвшүүлэх зэрэг хөтөлбөрүүдийг боловсруулж батлуулсан. | | | |
| | 18 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 сарын 7-ны өдрийн А/141 тушаалаар албан хаагчдын 2022 оны жилийн эцсийн ажлын гүйцэтгэлийг үнэлгээг баталгаажуулах чиг үүрэг бүхий үнэлгээний багийг нэгжийн дарга нарын болон хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан. Засгийн газрын мэдээллийн цахим сан болох www.plan.igoverment.mn программд нийт | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | албан хаагчид цахимаар гүйцэтгэлийн тайланг оруулж нэгжийн дарга нар нь үнэлгээг баталгаажуулсан бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Үнэлгээний баг хуралдаж албан хаагч тус бүрээр үнэлгээг баталгаажуулсан. Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн цахим хурлаар Төрийн нарийн бичгийн даргын буюу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хэлэлцэж 96.0 буюу “А” үнэлгээгээр үнэлсэн болно. Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Журам шинэчлэн батлах тухай 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшин үнэлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын хавсралтуудыг дагаж мөрдөн ажиллаж байна. Мөн төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшин үнэлэхтэй холбоотой журам, шийдвэрүүдийг шинэчлэн байгууллагын https://www.med.gov.mn/ цахим хуудсанд байршуулан ажилласан. | | | |
| | 19 | | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл - Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон "Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлэг Эдийн засгийн байнгын хороогоор 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцүүлсэн. Тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл, Төсвийн тухай хуулийн 8.4.3.төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. | | | |
| | 20 | | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны төсөв 99.24 хувийн гүйцэтгэлтэй гарсан . Үүнээс урсгал зардлын гүйцэтгэл 71.72 хувь, хөрөнгийн зардал 100 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Санхүүгийн тайланг хагас бүтэн жилээр гаргаж Сангийн яам, Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн. | 100% | 100% | |
| | 21 | | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Санхүүгийн тайланд 2022 оны аудитыг төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.5-т заасан хугацаанд хийлгэх тул хугацаа болоогүй байна. | Х.Б | Х.Б | |
| | 22 | | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний төлбөр 2022 онд гараагүй. | 100% | 100% | |
| | 23 | | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааныг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг үндэслэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулсан болно. Эдийн засаг, хөгжлийн яамны худалдан авах ажиллагааны 2022 оны нийт 441,175.000 /дөрвөн зуун дөчин нэгэн сая нэг зуун далан таван мянга/ төгрөгийн төсөвт өртөг бүхий 11 бараа, ажил, үйлчилгээнээс нийт 81,000.000 /наян нэгэн сая/ төгрөгийн төсөвтэй 2 бараа, үйлчилгээг 79,328.744 (далан есөн сая гурван зуун хорин найман мянга долоон зуун дөчин дөрөв) төгрөгөөр амжилттай зохион байгуулж, 1,671.256 (нэг сая зургаан зуун далан нэгэн мянга хоёр зуун тавин зургаа) төгрөгийг хэмнэсэн. | 100% | 100% | |
| | 24 | | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий | Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтыг үндэслэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулсан болно. | | | |
| | 25 | | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг үндэслэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулсан болно. | 100% | 100% | |
| | 26 | | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээнүүдийг яамны сайтад https://www.med.gov.mn/ байршуулж нийтэд ил тод мэдээлсэн. | 100% | 100% | |
| | 27 | | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | 2022 оны шилэн дансны хөтлөлт, хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан, зөвлөмжийг тухай бүр мөрдөн ажиллаж байгаа бөгөөд зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг тогтмол гаргаж, хяналт тавьж ажилласан. | 100% | 100% | |
| | 28 | | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер | Байгууллагын үйлчилгээг цахимжуулах цогц программ худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А-24 дүгээр тушаалаар “Байгууллагын үйлчилгээг цахимжуулах цогц программ худалдаж | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | авах ажиллагаа"-г зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 03/310 дугаар албан бичгээр энэ чиглэлээр ижил төсөөтэй үйл ажиллагаа явуулдаг 4 /"Ай ти групп" ХХК, "Супер ассист системс" ХХК, "Могул сервис энд саппорт" ХХК, "Супер ассист" ХХК/ байгууллагад үнийн санал ирүүлэх урилгыг хүргүүлсэн. Дээрх байгууллагуудаас дараах үнийн саналыг ирүүлсэн болно. Үүнд: "Ай ти групп" ХХК нь 63,970.000 төгрөгийн үнийн санал; "Супер ассист системс" ХХК нь 64,420.000 төгрөгийн үнийн санал; "Могул сервис энд саппорт" ХХК нь 59,585.644 төгрөгийн үнийн санал; "Супер ассист" ХХК-иас санал ирээгүй болно. Дээрхээс "Могул сервис энд саппорт" ХХК-ийн үнийн саналыг хүлээн зөвшөөрч, гэрээ байгуулах эрх олгож, гэрээг байгуулсан. | | | |
| | 29 | | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны худалдан авах ажиллагаанд үнэлгээ, аудитын шалгалтыг Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.5-т заасан хугацаанд хийх бөгөөд хугацаа болоогүй байна. | Х.Б | Х.Б | |
| | 30 | | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Эдийн засаг, хөгжлийн яам нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан босго үнээс давсан худалдан авах ажиллагааг зарлаагүй байгаа тул холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл байхгүй болно. | 100% | 100% | |
| | 31 | | 8.4.22. концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт; | Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь эрхзүйн мэдээллийн нэгдсэн систем legalinfo.mn сайтад нийтэд ил тод байршиж байна. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 32 | | 8.4.23. концессын гэрээ байгуулсан тухай бүрд концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл; | Концессын гэрээнүүдийг байгуулсан тухай бүрд нь яамны сайтад байгууллагын https://www.med.gov.mn/ нийтэд ил тод байршуулсан. Тус гэрээнд концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх болон бусад мэдээллүүдийг бүрэн оруулсан болно. | 100% | 100% | |
| | 33 | | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | Эдийн засаг, хөгжлийн яаманд 2022 оны жилийн эцсийн байдлаар төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй болно. | 100% | 100% | |
| | 34 | | 8.4.27. мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | 2022 оны жилийн эцсийн байдлаар тус яаманд захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байна. | 100% | 100% | |
| | 35 | | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг ил тод, нээлттэй www.shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр мэдээлсэн болно | 100% | 100% | |
| | 36 | | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, | Эдийн засаг, хөгжлийн яам нь чиг үүргийнхээ хүрээнд хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээ, үйл ажиллагаа, үйлчилгээнийхээ хариуд төлбөр, хураамж авдаггүй тул төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлс, төлбөр төлөх дансны мэдээлэл байхгүй болно. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлбөр төлөх дансны мэдээлэл; | | | | |
| | 37 | | 8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас хөрөнгө оруулагчдад олгосон зөвшөөрөл, гэрчилгээний мэдээллүүдийг Эдийн засаг, хөгжлийн яамны цахим хуудсанд байгууллагын https://www.med.gov.mn/ байршуулсан | 100% | 100% | |
| | 38 | | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | “Хөрөнгө оруулалтын тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/65 дугаар тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ахлуулсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр хүлээн авч яамны удирдлагуудад хэлэлцүүлэг хийж, газруудаас хуулийн төсөлд санал авсан. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл болон Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл болон 15 саналыг хуулийн төслийн үзэл баримтлалын төсөлд 2022 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 01/862 тоот албан | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | | | |
| | 39 | | 8.6.2. эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | Тус яаманд эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт байхгүй болно. | 100% | Х.Б | |
| | 40 | | 8.6.3. хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | Тус яаманд  хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэр байхгүй болно. | 100% | Х.Б | |
| | 41 | | 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Тус яаманд мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газар байхгүй болно. | 100% | Х.Б | |
| | 42 | | 8.6.5. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | Тайлбар: төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хүн, хуулийн этгээдтэй холбоотой асуудал нь тус яамны чиг үүрэгт хамаарахгүй  тул хасуулах саналтай. | Х.Б | Х.Б | |
| | 43 | | 8.6.6. төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон | Тайлбар: төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хүн, хуулийн этгээдтэй холбоотой асуудал нь тус яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах саналтай. | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | | | | |
| | 44 | | 8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ямар нэгэн байдлаар шилжүүлсэн асуудал байхгүй болно. | 100% | Х.Б | |
| | 45 | | 8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | Тус яамны явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл байхгүй. | 100% | 100% | |
| | 46 | | 8.6.11. барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг | 2022 оны жилийн эцсийн байдлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжиж дууссан, Улсын | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт; | комисс хүлээн авсан барилга, байгууламж байхгүй байна. | | | |
| | 47 | | 8.6.20. нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл; | Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны хүрээнд ашиглагдаж байгаа Гадаадын шууд хөрөнгө оруулалтын статистик тоон үзүүлэлт, Орон нутгийн хөгжлийн индексийн үзүүлэлтүүд /33 үзүүлэлт/, Аж үйлдвэрийн салбарын мэдээлэл, Үйлдвэрийн мэдээлэл, Үйлдвэрийн бүтээгдэхүүний мэдээлэл, Орон зайн мэдээллийн нээлттэй өгөгдлийг тус тус Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6-т зааснаар нээлттэй өгөгдлийн жагсаалтад оруулж, Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | 100% | 100% | |
| | 48 | | 8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт; | Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцаж байгаа албан хаагч одоогоор байхгүй болно. | 100% | Х.Б | |
| | 49 | | 8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:) | Хувь хүн, байгууллага, төрийн нууцаас бусад Нийтийн мэдээллийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан нээлттэй мэдээллүүдийг тухай бүр Эдийн засаг, хөгжлийн яамны цахим хуудас байгууллагын https://www.med.gov.mn/ болон Шилэн дансны мэдээллийн цахим www.shilendans.gov.mn системд тухай бүр байршуулсан. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | 50 | Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль 2021-12-24 Дугаар 2021-12-24 | 11.3. Улсын Их Хурлаас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд Улсын Их Хуралд ирүүлэх ба түүнд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлнэ. (11.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтны хариуцлагын асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлүүлэхээр тогтоол гаргана.) | УИХ-аас энэ хуулийн 11.2-т заасны дагуу Засгийн газарт өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жил болон сар бүр www.unelgee.gov.mn цахим байдлаар тайлагнаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухай бүр хүргүүлж ажилласан. | 100% | 100% | |
| | 51 | | 15.3. Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсан бол Засгийн газар уг тогтоолын хэрэгжилтийг тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй. | Монгол Улсын Их Хурлын 2020 оны 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг батлаж, тогтоолын 2 дугаар хавсралтаар “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”, 3 дугаар хавсралтаар “Хөгжлийн төслийн жагсаалт”, 4 дүгээр хавсралтаар “УИХ-ын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалт”, 5 дугаар хавсралтаар “УИХ-д 2022 онд үе шаттай өргөн мэдүүлж хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалт”-ыг тус тус баталсан бөгөөд хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дунджаар 58.4 хувийн биелэлттэй, “Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 40.2 хувь, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн 94 төслийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээс хэрэгжилт дунджаар 31.4 хувь, УИХ-ын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалт”-ийн хэрэгжилт 84.2 хувь, “УИХ-д 2022 онд үе шаттай өргөн мэдүүлж хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалт”-д 19 хуулийн төслийг батласнаас хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 78 хувийн биелэлттэй үнэлэгдсэнийг 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. | | | |
| | 52 | | 17.2. Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. | Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд 6 бүлэг, 23 зорилго бүхий нийт 300 төсөл, арга хэмжээ туссанаас 2022 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилт дунджаар 47.67 хувийн биелэлттэй үнэлэгдсэн бөгөөд “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3 заалтын ангилалд шилжүүлэн тооцвол, нийт батлагдсан арга хэмжээний 9.3 хувь буюу 28 арга хэмжээ үр дүнтэй, 22.3 хувь буюу 67 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн, 53.7 хувь буюу 161 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 14.7 хувь буюу 44 арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдлээ. Хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд 300 төсөл, арга хэмжээг 11.7 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөж, гүйцэтгэлээр 3.28 их наяд төгрөгийн санхүүжилт хийсэн нь нийт төсөвлөсөн дүнгийн 27.98 хувийг эзэлж байна. Тайланг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 13/699 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн . | 100% | 100% | |
| | 53 | | 18.5. Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. | хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д тусгагдсаны дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 2021 оны явцын тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 2/35 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тайланг Засгийн газрын хуралдаанаар танилцуулж, УИХ-ын байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэн, 2022 оны 3 дугаар сарын 31-нд УИХ-ын нэгдсэн чуулганд танилцуулсан. | | | |
| | 54 | | 19.5. Засгийн газар Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс зургаан сарын өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. | Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд 2022 оны 7 дугаар сарын 5-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд Улсын Их Хурлаар батлагдаагүй байх тул Төрийн аудитын байгууллагад хүргүүлэх хугацаа болоогүй. | Х.Б | Х.Б | |
| | 55 | | 20.4. Засгийн газар урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс зургаан сарын өмнө Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050" хөгжлийн бодлогын баримт бичгийн 2022 оны жилийн эцсийн байдлаар явцын тайланг 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 01/1565 тоот албан бичгээр, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгийн 2022 оны жилийн эцсийн явцын тайланг 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 01/1566 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн. | 100% | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 56 | Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-06-17 Дугаар 2023.01.01 | 7.1.5. Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална. | Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Бүгд Найрамдах Сингапур Улсын дэлхийд нэр хүндтэй зөвшөөрлийн цахим сангийн үйл ажиллагаа, цахим хөгжүүлэлтийг судалж, монголын онцлогт тохируулан нэвтрүүлэх зорилгоор УИХ-ын гишүүн Х.Ганхуяг, Ч.Ундрам, Б.Пүрэвдорж нараар ахлуулсан ажлын хэсэг ажилласан бөгөөд тус ажлын хэсгээс гарсан санал, Сингапур Улсын туршлагаас зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбоотой асуудлуудыг журмын төсөлд тусган боловсруулсан. Төрийн нийтийн өмч буюу байгалийн баялгийг ашиглахтай холбоотой зохицуулалтууд, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох 248 зөвшөөрөл, иргэн болон өрхийн нэг удаагийн 114 энгийн зөвшөөрлийг кодолсон. | 70% | 70% | |
| | 57 | | 3.3.3. Энэ зүйлийн 1-д заасан эрх шилжүүлэх журмыг Засгийн газар батална. | Зөвшөөрөл олгох эрхээ төрийн холбогдох байгууллага, албан тушаалтан, эсхүл Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.7-д заасан хуулийн этгээдэд шилжүүлэхтэй холбоотой журмын төслийг боловсруулж, холбогдох яамдаас санал авахаар бэлтгэж байна. | 70% | 30% | |
| | 58 | | 2.3.2. Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрлийн кодыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, барааны ангиллын жагсаалт болон үндэсний кодыг харгалзан тогтооно. | Зөвшөөрлийн хуулиар олгох зөвшөөрлүүдийг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, барааны ангиллын жагсаалт болон үндэсний кодыг харгалзан бүрэн кодолсон. Төрийн нийтийн өмч буюу байгалийн баялгийг ашиглахтай холбоотой зохицуулалтууд, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | олгох 248 зөвшөөрөл, иргэн болон өрхийн мөн нэг удаагийн 114 энгийн зөвшөөрлийг кодолсон. | | | |
| 6 | 59 | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01 | 23.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтооно. | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн А/100 дугаар тушаалаар Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 62 дугаар тушаалаар батлагдсан “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх журам”, “Чөлөөт бүсэд тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгох журам”, “Чөлөөт бүсэд эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг тус тус шинэчлэхээр ажлын хэсэг байгуулагдан ажиллаж холбогдох төрийн байгууллага болон ашиг сонирхол нь зөрчигдөх аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг тусгасан бөгөөд журмыг батлах шатанд явж байна. Тус журмын төслийг боловсруулахдаа Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуультай уялдуулан боловсруулагдаж байна. Журмын төсөлд үйл ажиллагааны цагийн хязгаарын зохицуулалтыг тусгасан. | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |
| УИХ-ын тогтоол | | | | | | | |
| 7 | 60 | Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй | ЭЗХЯ хуулийн төсөл 2020. -Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль/Шинэчилсэн найруулга/ -Холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр баталсан. Энэ хуулиар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-01-09 Дугаар 2020 №02 | | төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлах, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх харилцааг зохицуулсан. Хууль баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр хуулиуд дахь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн нэр, төрлийг дагалдах 51 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. | | | |
| 8 | 61 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2020-05-07 Дугаар 2020 №45 | 1.2/. Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг энэ хуульд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд 2022 оны 6 дугаар сард багтаан өргөн мэдүүлэх; | Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг хуульд нийцүүлэх ажлын хүрээнд мэдээллийг бүрдүүлэн үндэсний, салбарын, салбар дундын болон орон нутгийн хэмжээнд мөрдүүлэхээр баталсан нийт 566 бодлогын баримт бичгийн мэдээллийг бүрдүүлж, тэдгээрт дүн шинжилгээ хийсэн. 1. Улсын Их Хурлаас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нийт 53 баримт бичиг, Улсын Их Хурлын харьяа байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталсан 2 баримт бичиг байна. Эдгээрээс а) хүчин төгөлдөр хэвээр үлдээх, б) хүчингүй болсонд тооцох саналыг боловсруулсан. Улсын Их Хурлын тогтоолоор баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийг хуульд нийцүүлэх талаарх дүн шинжилгээний танилцуулга, Засгийн газрын шийдвэрийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан, 2. Засгийн газар, түүний гишүүн, төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 197 үндэсний, салбарын болон салбар дундын | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт байна. Эдгээрээс а) хүчин төгөлдөр хэвээр үлдээх б) хүчингүй болсонд тооцох саналыг тус тус боловсруулсан. 3. Улсын Их Хурлын 2021 оны 89 дүгээр тогтоолоор 17 хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор 62 хөгжлийн бодлогын баримт бичиг хүчингүй болсон. Үлдсэн баримт бичгүүдийг хуульд нийцүүлэн Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн төсөлд тусган, 2022 оны 6 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. | | | |
| 9 | 62 | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52 | 3.3/. Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас баталсан дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэх арга хэмжээг авах; | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого нь 30 жилд хэрэгжих баримт бичиг бөгөөд түүнийг дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогод тусган хэрэгжүүлэх юм. 1) 2021 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18.2-т заасан цаглаврын дагуу “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, 2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 01/241 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Төлөвлөгөөний төсөлд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 1 дүгээр үе шатанд хэрэгжих 114 үйл ажиллагаатай уялдсан. 2) “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2022 оны 4 дүгээр сарын 20-ны 57 | 100% | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дугаар захирамжаар, Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг боловсруулах үүрэг бүхий Ажлын дэд хэсгүүдийг Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А-38 дугаар тушаалаар тус тус баталсан. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн төслийг 2022 оны 6 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. | | | |
| 29 | 107 | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-10-26 Дугаар 2022_385 | 3. 3. Онцгой дэглэмийн хугацаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг бүрэн хангаж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд даалгасугай: 3.1. компанийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, шинэчлэх, шаардлагатай бол нэгжийн удирдлага, холбогдох албан тушаалтныг томилж, чөлөөлөхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад; 3.2. компанийн хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны тусгай журам тогтоож, тэдгээрийг зөрчигчдөд зохих хариуцлага хүлээлгэж ажиллахыг Засгийн | Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцыг 2 долоо хоног тутам буюу 2022 онд нийт 5 удаа Засгийн газрын хуралдаанд танилцуулаа. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд төрийн өмчит болон бусад холбогдох ашигт малтмал экспортлогчид, болон бусад холбогдох байгууллагуудын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд тогтмол хяналт тавьж ажиллав. Мөн тус компаниас валютын орлого төвлөрүүлэх, экспорт, тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, ашигт малтмалын олборлолт, боловсруулалт, тээвэрлэлтийн гэрээг ил тод болгох чиглэлээр цогц ажлууд авч хэрэгжүүлсэн. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад; 3.3. Тавантолгой нүүрсний ордоос нүүрс ачих, тээвэрлэх, худалдан борлуулах, хил нэвтрүүлэх бүхий л үе шатанд хяналтыг сайжруулах шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад, энэ чиглэлээр бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд; 3.4. компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; 3.5. “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Ж.Ганбатад. | | | | |
| 30 | 108 | “Цагааннуур” чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх тухай 2022-11-23 Дугаар 2022_412 | 2. “Цагааннуур” чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэхтэй холбогдуулан гааль, мэргэжлийн хяналт, дотоодын цэрэг зэрэг төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн албадын үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар нарт, Цагааннуур тосгоноос чөлөөт бүс хүртэл шилэн кабелийн сүлжээ байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд тус тус үүрэг болгосугай. | 1. Цагааннуур” чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэхтэй холбогдуулан ЭХЯ-нд 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/1693 дугаар албан тоотыг хүргүүлсэн. ХЗДХЯ-нд 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 01/1614 дугаар албан тоотыг тус тус хүргүүлсэн. 2. Цагааннуур тосгоноос чөлөөт бүс рүү шилэн кабель татах асуудлыг судалж шийдвэрлэж өгөх хүсэлтийг 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 156 тоот албан бичгээр Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-д хүргүүлсэн. 3. Баян-Өлгий аймгийн Гаалийн газар, Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газраас чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг шийдвэрлүүлж өгөх хүсэлтийг уламжилсан. 4. Цагааннуур чөлөөт бүсэд тээвэр, логистикийн төв байгуулах боломжийг хамтран судлах, ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах хүсэлтийг Зам, тээврийн хөгжлийн яаманд уламжилсан. 5. Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж буй Инженер геодези ХХК-аас санал болгож буй одоогийн орц гарцын байршлыг өөрчлөх саналыг судлан үзэх хүсэлтийг 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 142 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд тус тус уламжилж чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлд анхаарч ажиллаж байна. | 100% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 109 | | 3. Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай зардлыг 2023 оны батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай. | 1.Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдох зарим зардлыг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэж байна. 2.Засгийн газрын 2015 оны 126 дугаар тогтоол, Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 93 дугаар тушаалаар батлагдсан орон тооны хязгаарын дагуу 23 албан хаагчийн бүрэлдэхүүний үйл ажиллагаанд шаардагдах нэмэлт санхүүжилтийг шийдвэрлүүлж өгөх хүсэлтийг уламжилсан. 3.“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн жагсаалт”-ыг баталсан. Батлагдсан жагсаалтад “Чөлөөт бүсийн инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл /Баян-Өлгий, Ногооннуур сумын 9-р баг Цагааннуур тосгон/” гэсэн нэршлээр 250 сая төгрөгийн санхүүжилтийг 2023 онд хуваарилахаар шийдвэрлэсэн. | 100% | 100% | |
| 31 | 110 | Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_413 | 2.7. “Алтай дайхан холдингс” ХХК-ийн газрын тусгай зөвшөөрлийг орон нутгаас хүчингүй болгосонтой холбоотой үүссэн гомдлыг судалж, хуулийн дагуу шийдвэрлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж нарт. | Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 413 дугаар тогтоолын биелэлтийг ирүүлэх тухай албан бичгийг холбогдох яамдад хүргүүлсэн. | 70% | 70% | |
| | 111 | | 3. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнг сар тутам Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны | “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 413 дугаар тогтоолын биелэлтийг ирүүлэх тухай албан бичгийг холбогдох яамдад хүргүүлсэн. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | | | | |
| | 112 | | 4. Энэ тогтоолын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцуулах саналаа томилох эрх бүхий албан тушаалтан, байгууллагад хүргүүлж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт үүрэг болгосугай. | “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 413 дугаар тогтоолын биелэлтийг ирүүлэх тухай албан бичгийг холбогдох яамдад хүргүүлсэн.Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж, “Ийст коридор рэйлрөүд” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-тай хамтран ажиллахаар тохиролцсон. Төслийн сонгон шалгаруулалтад санал өгсөн оролцогч байгууллагаас гомдол гарсан тул шүүхийн шатанд хянан шийдвэрлэгдэж байна. | 70% | 70% | |
| 32 | 113 | Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_417 | 3. Мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжиж байгаатай холбогдуулан холбогдох яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих өөрчлөлт оруулах шийдвэрийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд, энэ тогтоолын 2.3-т заасан улсын байцаагч нарыг яамны зохих | Мэргэжлийн хяналтын чиг үүргийг Төрийн хяналтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу салбар яамд руу шилжүүлэхтэй холбоотой Эдийн засаг, хөгжлийн яамны  чиг үүрэгт шилжиж ирэх чиг үүрэг байхгүй болно | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүтцийн нэгжид шилжүүлэн ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | | | | |
| 33 | 114 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419 | 1. Төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх эдийн засгийн боломжийг орон нутаг бий болгох чиглэлээр холбогдох тооцоо, судалгаа хийж, тодорхой төсөл, хөтөлбөр, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулж, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зорилт болгон тусгаж батлуулахыг аймгийн Засаг дарга нарт, энэ чиглэлээр шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт тус тус үүрэг болгосугай. | Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр бүх аймгийн Засаг даргын орлогч, салбарын дэд сайд нарт "Орон зайн хөгжлийн бодлого төлөвлөлт"-ийн чиглэлээр холбогдох мэдээллийг танилцуулж, орон нутгийг хөгжүүлэх нөөц, боломжийн талаар санал солилцсон. Мөн НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Канад Улсын Засгийн газрын MERIT төслийн дэмжлэгтэйгээр Эдийн засаг хөгжлийн яам, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Тогтвортой хөгжил-Шинэ сэргэлтийн бодлого Дундговь" хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт “Палеонтологийн нөөцөд тулгуурлан амралт судалгаа, аяллын цогцолборыг Дундговь аймагт байгуулах боломж” төслийг танилцуулж, орон нутгийн удирдлага, иргэд, аж ахуйн нэгж, удирдлагуудтай санал солилцож, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. | 100% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх, өөрөө өөрийгөө нэмэгдүүлэх жагсаалт гараагүй. Дундговьт тусгайлсан байдлаар гараагүй. |
| | 115 | | 2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга | "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын төсөлд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох зорилт, үйл ажиллагааг төлөвлөн тусгасан. Мөн орон зайн мэдээллийн системд тулгуурласан "Шилжилт хөдөлгөөнийг зохицуулах дашбоард"-ыг хөгжүүлж туршилтын хувилбарыг Булган, Хэнтий аймагт хэрэгжүүлсэн. Энэхүү систем | 70% | 0% | Энэ чиглэлээр эрх зүйн шинэчлэлийн судалгаа хийгдээгүй. Хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 116 | | хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай. | нь дотоод шилжилт хөдөлгөөний менежментийг сайжруулахад оролцогч талуудын чадавхыг нэмэгдүүлэх, шилжилт хөдөлгөөнийг уялдаа холбоотой цогц байдлаар зохицуулах, иргэн, аж ахуй байгууллага орон нутагт шилжих шийдвэр гаргалтад цогц мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий цогц платформ юм. "Шилжилт хөдөлгөөнийг зохицуулах дашбоард"-ын эхний хувилбарыг Монгол Улсын Ерөнхий сайдын 157 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт танилцуулсан. | | | хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулаагүй. |
| | 116 | | 5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай. | Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд  харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нэгж байхгүй. | 100% | 0% | Хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах |
| 34 | 117 | Хилийн боомтуудын төмөр замын талаар авах арга хэмжээний | 1. Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр замын техникийн нөхцөл, бүтээн байгуулалтын асуудлаар | ЗГХЭГ-ын даргын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 77-р тушаалаар хилийн Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажлын явц байдал, хэрэгжилтийг судлан үзэж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын | 70% | 30% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тухай 2022-12-07 Дугаар 2022_446 | хятадын талтай хэлэлцээ хийж, үр дүнг танилцуулж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгасугай. | хэсгийн бүрэлдэхүүнд Эдийн засаг, хөгжлийн дэд сайд оролцож ажилласан.  Тус ажлын хэсэг 2022.11.7 болон 2022.11.14-нд тус тус хуралдаж өнөөгийн нөхцөл байдал, боомтод хийгдэж буй бүтээн байгуулалт болон цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар хэлэлцсэн. Тус ажлын хэсгийн ажлын үр дүн болон хилийн төмөр замын асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ЗГХЭГ-ын даргад танилцуулсан. Хил дамнасан төмөр замын асуудлыг хятадын төмөр замын байгууллагатай нарийвчлан тогтоох хэлэлцлийг Монголын талаас Монголын төмөр зам ХК хариуцах талаар Гадаад харилцааны яамаар дамжуулан ноот бичгээр хүргүүлсэн. Тус асуудлаар холбогдох байгууллагатай уулзалт зохион байгуулах ажлын ЭСЯ хариуцан ажиллаж байна. Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс Монгол, Хятадын хилийн Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр замын техникийн нөхцөл, бүтээн байгуулалтын асуудлаар БНХАУ-ын Хөгжил шинэчлэлийн хороо хоорондын цахим хурлыг зохион байгуулахаар саналаа хүргүүлсэн боловч тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна. | | | |
| | 118 | | 3. Хилийн төмөр замын Ханги-Мандал боомтыг “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т нэмж тусгах талаар хятадын талтай хийж байгаа хэлэлцээг эрчимжүүлж, 2023 оны эхний хагас жилд багтаан тохиролцох арга хэмжээ авч ажиллахыг Эдийн | Эдийн засаг, хөгжлийн яамны төлөөлөл  Хилийн төмөр замын Ханги-Мандал боомтын ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд ЗТХЯ, МТЗ болон төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэгч компанийн төлөөллийн хамт 2023 оны 1 дүгээр сарын 11-13-ны өдрүүдэд ӨМӨЗО-ны Бугат хотын Мандал боомтод ажиллаж ӨМӨЗО-ны Хөх хотын төмөр замын групп, Бугат хотын ардын засгийн ордон, Хятадын төмөр замын зураг төслийн корпорацын Өвөр монголын төмөр замын судалгаа, зураг төслийн хүрээлэнгийн төлөөлөлтэй уулзалт | 100% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгасугай. | хийлээ. Тус уулзалтаар Ханги-Мандал боомтын хилийн төмөр замыг бодлогын баримт бичигт тусгуулах, холбох арга хэмжээг албажуулах шаардлага болон хилийн төмөр замын холбох цэг, өндөржилт зэрэг асуудлын шийдлийг инженер техникийн мэргэжилтнүүдийн түвшинд харилцан санал солилцож тохиролцон зураг төслийг уялдуулах, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар хамтран ажиллахаар болсон. Уулзалтын үед Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс хилийн төмөр замыг холбогдох бодлогын баримт бичигт тусгуулах талаар арга хэмжээ авахыг айлын талд санал тавьсан. Харин Хөх хотын төмөр замын групп компанийн төлөөлөл тус төмөр замыг бүтээн байгуулах болон хил дамжин байгуулах асуудлыг өөрсдийн дотоод хууль тогтоомжийн хүрээнд дээд шатны байгууллагадаа уламжлахаар төлөвлөн бэлтгэл ажлаа хангаж байгаа талаар мэдэгдсэн. | | | |
| 35 | 119 | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448 | 2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн | 1.Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу дэд болон хэмнэх албан тушаалтны орон тоо байхгүй болно. 2.Эдийн засаг, хөгжлийн яамны 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлж, батлуулсан. 3.Тус яам 2023 онд зохион байгуулсан сургалтуудыг цахимаар зохион байгуулахад анхаарч ажиллаж байна. 4.Эдийн засаг, хөгжлийн яам нь 2022 онд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулаагүй, төсвөөс хөрөнгө зарцуулаагүй болно. | 100% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх;<br>2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем<br>(PIMIS-<br>www.publicinvestment.gov.mn)- | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах. | | | | |
| 36 | 120 | “Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-09 Дугаар 2022_450 | 3.5. . компанийн хөрөнгө оруулалт, бизнес төлөвлөгөөнд заасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт, үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн хамтарсан хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт; | Засгийн газрын 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд удирдлага, зохион байгуулалт, өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй ажлын үр дүн, тулгамдаж буй асуудлуудыг Засгийн газрын хуралдаанд 14 хоног тутам танилцуулж, Засгийн газрын хуралдааны 7 тэмдэглэл гарч, холбогдох Засгийн газрын гишүүн, албан тушаалтнуудад өгөгдсөний үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажилласан. Уг ажлын хүрээнд ““Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 385 дугаар тогтоол, ““Тавантолгой” ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 450 дугаар тогтоолын хэрэгжилтийг биелэлтэд байнгын хяналт тавьж ажилласан. | 100% | 100% | |
| 37 | 121 | Жагсаалт батлах тухай 2022-12-14 Дугаар 2022_460 | 2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Тус тогтоолд заасан төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай холбогдох мэдээллүүдийг гаргуулах тухай бүх ТЕЗ болон 21 аймгийн засаг дарга нарт 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/1459, 01/1460 тоот албан бичгүүдийг хүргүүлсэн. Ирүүлсэн санал, мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх ажлууд хийгдсэн. | 100% | 100% | |
| 38 | 122 | Журам батлах тухай 2022-12-14 | 2. Энэ тогтоолын 1-д заасан цахим арилжаанд хяналт тавих журмыг хамтран баталж, | Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулж буй “Цахим арилжаанд хяналт тавих журам”-ын төсөлд албан бичгээр санал хүргүүлсэн. Засгийн газрын | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2022_466 | мөрдүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт үүрэг болгож, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-д зөвлөсүгэй. | хуралдааны 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын хүрээнд 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр нүүрсний цахим биржийн анхны арилжааны туршилт амжилттай хийгдсэн. | | | |
| Ерөнхий сайдын захирамж | | | | | | | |
| 39 | 123 | Ажлын хэсэг байгуулах тухай 2022-06-28 Дугаар 2022_96 | 2. Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөлт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөө баталж, удирдлага, зохион байгуулалтаар хангаан ажиллах, явцын тайланг 2022 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Жавхлан)-т даалгасугай. | “Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 04 тоот албан даалгавар гарсан. Ажлын хэсгийн анхны хурлыг 2022 оны 07 дугаар сарын 06-ний өдөр нарийвчилсан төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлэн боловсруулж Ажлын хэсгийн даргад танилцуулсан. Монгол улс, БНХАУ-ын Замын-Үүд, Эрээний “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах” хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт тусгагдсаны дагуу хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Хятадын талын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр БХБЯ-ны 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 03/826 тоот албан бичгээр хүргүүлсэн. БХБЯ-ны захиалгаар “Алтанбулаг” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад “Идеал групп” ХХК болон “Некст степ инженеринг” ХХК нарын түншлэл шалгарч тус ажлыг 2022 оны 6 дугаар сарын 7-ны өдөр 2022/304 тоот гэрээ байгуулан гүйцэтгэж байна. 1. Барилга хот байгуулалтын яам, Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨУҮГ-тай байгуулсан №2022/23 тоот гэрээний дагуу Хөшигийн хөндийн Эдийн засгийн | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлын эцсийн тайланг танилцуулсан. 2. Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн дэд бүтцийн зураг, төслийн ажлыг яаралтай эхлүүлэх, хэсэгчилсэн дэд бүтцийг уламжлалт болон орчин үеийн ухаалаг технологитой хослуулах шийдлийг боловсруулж, танилцуулах шатандаа явж байна. 3.Чөлөөт бүсийн менежментийг төр хувийн хэвшлийн түншлэл хэлбэрээр байгуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх саналыг төслийг боловсруулж, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын үндэсний хороонд танилцуулсан. | | | |
| 40 | 124 | Ажлын хэсэг байгуулах тухай 2022-07-20 Дугаар 2022_107 | 2. Хилийн Цагаандэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай: Ажлын хэсгийн ажлын явцын тайланг 2022 оны 8 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг (Б.Жавхлан)-т даалгасугай. | Цагаандэл-Уул боомтыг нээн ажиллуулахад тулгамдаж буй асуудлыг Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж санал дүгнэлт гаргуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2022 оны 7 дугаар сарын 20- ны өдрийн 107 дугаар захирамжаар байгуулсан. Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А71 тоот тушаалаар Ажлын дэд хэсгийг байгуулсан. Тус ажлын хүрээнд “Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөлийг Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор батлуулж, 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн Засгийн газрын 344 дүгээр тогтоолоор бүрэлдэхүүнд нэмэлт оруулсан. Ажлын хэсгийн гишүүдийн зүгээс шинэ сэргэлтийн бодлогод туссан хөгжлийн төслүүдийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн бөгөөд Цагаандэл-Уул хилийн боомтын асуудлыг дахин нарийвчлан хэлэлцсэн. Энэ шийдвэрийн хүрээнд Цагаандэл-Уул боомтыг нээхтэй холбоотой дэд ажлын хэсгийг 2022 оны 10 дугаар сарын 7-ны өдөр хуралдуулж зарим асуудлыг хэлэлцүүлэн Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан Ажлын хэсэгт | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | танилцуулахаар Ажлын хэсгийн нарийн бичгийн даргад танилцуулсан. | | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 41 | 125 | 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр 5 дугаар тэмдэглэл 2022-01-19 Дугаар 2022_5 | XYIII.5. . Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоол болон “Шинэ төмөр зам төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал | Засгийн газрын хуралдааны 2022 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр 5 дугаар тэмдэглэлд заасны дагуу Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/88 дугаар тушаалаар Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Бичигт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замын төслүүдийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулсан. Мөн “Монголын төмөр зам” ТӨХК-иас дээрх төслүүдэд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад дотоодын хөрөнгө оруулагч сонгох, хэлэлцээ хийх ажлыг зохион байгуулахаар, хөрөнгө оруулагч сонгон шалгаруулах урилгыг нийтэд зарлан, хөрөнгө оруулагчийг сонгохоор ажиллаж шалгаруулалтын баримт бичгийг боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 179 дугаар тогтоолоор тус төслүүдийн концессын сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зарлаж, зохион байгуулан дүгнэхийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт даалгасан тул тус яамыг хэрэгжилтээс хасах саналтай байна. | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | О.Батнасан нарт тус тус даалгав. | | | | |
| 42 | 126 | 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр 6 дугаар тэмдэглэл 2022-01-26 Дугаар 2022_6 | IX.6.4. Автомат удирдлага бүхий жолоочгүй чингэлэг тээврийн систем нэвтрүүлэх төслийг төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээгээр хэрэгжүүлэх талаар судалж, танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан нарт. | Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 01/1990 дугаартай албан бичгээр Замын үүдийн чөлөөт бүсэд автомат удирдлагатай тээвэр, тулгуурт гүүрэн байгууламж дүүжин тээвэр бүхий чингэлэг тээврийн терминал, Бичигт хилийн боомтод шилжүүлэн ачих терминал барих ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх талаар Засгийн газрын тэмдэглэлийн төслийг ирүүлсэн. Тус төслүүд нь төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусаагүй байсан тул Концессын тухай хуулийн 9.4-т заасны дагуу төслийн саналаа зардал, үр ашгийн тооцооллын хамт ирүүлэх тухай 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 01/476 тоот албан бичгийг хүргүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2022 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 01/3541 тоот албан бичгээр Гашуунсухайт боомтод автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах төслийг концессын зүйлийн жагсаалтад нэмэлтээр оруулах саналыг зардал үр ашгийн урьдчилсан тооцооллын хамт ирүүлсэн. Тус төслийн зардал үр ашгийн тооцооллыг хянаж Сангийн яамнаас хуульд заасны дагуу зөвшөөрлийг аван, Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгах саналыг Засгийн газрын тогтоолын төслийн хамт боловсруулж яамдаас санал авсан. Хууль зүй дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 11-ны өдрийн “Санал өгөх тухай” 1/4183 тоот албан бичгээр “Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 110 дугаар захирамжаар хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлэх, боомтын дэд бүтцийг нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлэх, боомтын дэд бүтцийг хөгжүүлэх, нүүрс тээвэрлэлт | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | экспортын гарцыг нэмэгдүүлж, ачаа тээврийн урсгалыг сайжруулах, хилийн боомтод жолоочгүй тээврийн хэрэгслийг ашиглах санал дүгнэлт гаргаж Засгийн газарт танилцуулахыг даалгасан тул дээрх санал, дүгнэлтэд үндэслэж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж” хасах санал ирүүлсэн. Тус яамны зүгээс чиг үүргийн хүрээнд холбогдох ажлыг бүрэн хийсэн болно. | | | |
| | 127 | | IX.16. . Төвийн бүсийн эрчим хүчний 5 дахь эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр барих төслийн талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Төвийн бүсийн 5 дахь эх үүсвэрийг бий болгох ажлын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж байгаа Бөөрөлжүүтийн нүүрсний уурхайг түшиглэн барих 300 МВт-ын цахилгаан станцыг (Багахангай) барьж байгуулах, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүргийг хариуцагч Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав. | Концессын тухай хуулийн 9.4-т “Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10.1-д заасан жагсаалтад оруулах концессын зүйлийн талаарх энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлнэ” гэж заасны дагуу тухайн төслийг төр, хувийн хэвшлийн түншлэл концессын гэрээгээр хэрэгжүүлэхийн тулд тус төслийн талаарх тооцоо судалгаа нь Эрчим хүчний яаман дээр хийгдэж байна. Тус тооцоо судалгааг дуусган, салбар яамнаас саналаа ирүүлсний дараа манай яамнаас тооцоо судалгааг нягтлан үзэж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | 128 | 2022 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 8 дугаар тэмдэглэл 2022-02-01 Дугаар 2022_8 | YII.7. . БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Багануур Пауэр” ХХК-ийн хэрэгжүүлж буй 400 МВт-ын хүчин чадалтай Багануурын цахилгаан станцын төслийн хэрэгжилтийн явцын талаар Эрчим хүчний сайд Н.Тавинбэх Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан төслийн санхүүжилтийн асуудлаар БНХАУ-ын холбогдох байгууллагатай дипломат шугамаар харилцан дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүргийг хариуцагч Б.Жавхлан нарт тус тус даалгав. | Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлд “Шинэ сэргэлтийн бодлого”, Хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийн явц, биелэлтийг Засгийн газрын хуралдаанд сар тутам танилцуулахыг даалгасны дагуу Багануур ДЦС төслийн хэрэгжилтийн талаар Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 28 дугаар хуралдаанд танилцуулж, Багануурын дулааны цахилгаан станцын төслийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Хятадын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороотой хэлэлцээ хийж, төслийн ажлыг үргэлжлүүлэх талаар холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг холбогдох сайд нарт даалгасан. "Багануур Пауэр" ХХК-аас 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн BPP-2022-008 тоот албан бичгээр "Багануурын цахилгаан станц төсөл"-ийн хувьцаа эзэмшигчийг солих хүсэлтийг Эдийн засаг, хөгжлийн яаманд ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан 2022 оны 8 дугаар сарын 16-ны өдөр "хувьцаа шилжүүлэх тухай” Консорциумын хамтарсан шийдвэр болон Консорциумд нэгдэх байгууллагыг тодорхой болгох мөн тус төслийн санхүүжилттэй холбоотойгоор БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос журам батлагдсан тул хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж, концессын гэрээнд заасны дагуу “бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх" тухай 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 03/889 тоот албан бичгийг хүргүүлсэн. | 100% | 100% | |
| 44 | 129 | 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 | XYIII.9. . Экспортын бараанд ногдож буй тарифын болон тарифын бус саад, бэрхшээлийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийж, бууруулах чиглэлээр | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/984 тоот албан бичгээр Засгийн газрын тэмдэглэлээр даалгасан арга хэмжээнд санал авсан бөгөөд Эдийн засаг, хөгжлийн яам холбогдох тооцоолол судалгааг хийж, экспортын үйл ажиллагааг дэмжих зорилгоор | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2022_16 | холбогдох гэрээ, хэлэлцээр байгуулах саналын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан экспортын бараанд ногдож буй тарифын болон тарифын бус саад, бэрхшээл, хүндрэлтэй асуудлыг ангилж авч үзэх, холбогдох тусгай зөвшөөрөл, эрх олгох, стандарт тогтоох асуудлыг цөөлөх, бууруулах чиглэлээр холбогдох тооцоо, судалгаа хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт 2022 оны 4 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт нарт даалгав. | гадаад улс, байгууллагатай байгуулсан чөлөөт худалдааны гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг идэвхжүүлэх, ойрын хугацаанд нэгдэн орохоор судалж байгаа худалдааны гэрээ, хэлэлцээрийг эрчимжүүлэх, экспортын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн бүрдүүлдэг бичиг баримт бүрдүүлэлтийг цахимжуулж, цаг хугацааг хэмнэж, урсгал зардлыг багасгах, экспортын үйл ажиллагаатай хамаарал бүхий татвар, тариф, хөнгөлөлт чөлөөлөлтийн хууль эрхзүйн зохицуулалтыг сайжруулах, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал, эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомт, логистикийн төвийн төлөвлөлтүүдийг цогц байдлаар төлөвлөж, экспортыг дэмжсэн гарцуудыг бий болгох бодлого барьж ажилласан. Иймд Боомтууд дээр хийгдэж буй үндсэн болон нэмэлт дэд бүтцийн ажлуудын гүйцэтгэлд хяналт хийж, ашиглалтад орох хугацааг түргэсгэх (Шивээхүрэн боомт дээр Бөмбөлөг систем үүсгэх, Бичигт боомт дээрх терминалыг ажилд оруулах, Ачааны машинуудын цасыг хурдан цэвэрлэх нөхцөл бүрдүүлэх, Төмөр замын холболтууд), Гашуунсухайт боомт дээрх чингэлэгт тээврийн терминалыг бүрэн хүчин чадлаар нь ашиглах чиглэлээр арга хэмжээнүүдийг зохион байгуулах саналыг Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 01/341 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | | |
| 45 | 130 | 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдөр 18 дугаар тэмдэглэл | XI.1.1. 1. “Ажлын хэсэг байгуулах тухай” 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Ерөнхий сайдын 104 дүгээр захирамжид өөрчлөлт оруулах | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлд Хуурай боомтын боомтын асуудал хариуцсан нэгж байгуулахтай холбогдуулан Ерөнхий Сайдын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 104 | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022-03-30 Дугаар 2022_18 | саналаа танилцуулахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт; | дүгээр захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, олон улсын хуурай боомт байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж танилцуулахыг даалгасны дагуу холбогдох яам, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод тус ажлын хэсэгт оруулах төлөөллийн нэр ирүүлэхийг хүссэн албан тоотыг хүргүүлж “Ажлын хэсэг байгуулах тухай” Ерөнхий сайдын захирамжийн төслийг боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01/1636 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын тухай хуулийн 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргатай байхаар хуульчлагдсан тул хуурай боомтын асуудлыг тус сайд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэнэ. Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн болно. | | | |
| 46 | 131 | 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 22 дугаар тэмдэглэл 2022-04-13 Дугаар 2022_22 | XYIII.5. . -Цаашид гадаад улс болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл, их хэмжээний тусламжийг зөвхөн Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан зургаан чиглэлийн сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжих төслүүдэд ашиглаж байх талаар хууль тогтоомжийн төсөл боловсруулан батлуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн | Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хөгжлийн түнш орнууд болон олон улсын байгууллагуудаас олгож буй санхүүжилтийг Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан 6 сэргэлтийн бодлогын хүрээнд зарцуулахаар тусгасан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлийг батлуулсан. Хөгжлийн түнш орнууд, олон улсын байгууллагатай хурал, зөвлөгөөн хийхэд болон цаашдын хамтын ажиллагаанд баримтлах стратегийг харилцан тохиролцох, ажлын түвшинд хуралдахад Шинэ сэргэлтийн бодлогыг урьтал болгож ажиллах талаар | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгав. | хөгжлийн түншүүдэд шат дараатайгаар мэдэгдэж, танилцуулсан. | | | |
| 47 | 132 | 2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр 24 дүгээр тэмдэглэл 2022-04-20 Дугаар 2022_24 | XIY.2. . “Концессын гэрээ цуцлах тухай” Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 148 дугаар тогтоолын дагуу “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг “Кью Эс Си” ХХК-аас шилжүүлэн авах чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн талаар Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авахыг Засгийн газрын холбогдох гишүүн, албан тушаалтанд даалгав:<br>1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК болон “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг бүс нутгийн уул уурхай, металлургийн кластер хэлбэрээр хөгжүүлэх талаар судлан санал боловсруулж танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Х.Бадамсүрэн)-т; | Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК -аас "Монгол ган цогцолбор I" төслийн хэлэлцүүлгийг 2022 оны 07 дугаарын сарын 4-ний өдөр зохион байгуулагдсан. Тус хэлэлцүүлэгт Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Баттөмөр, Уул уурхайн сайд Г.Ёндон, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал болон яамны газрын дарга нар холбогдох яамдын газрын дарга нар, хувийн хэвшлийн төлөөлөл оролцсон. | 70% | 30% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 133 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XYI.10. Дорноговь аймгийн Сайншанд хотоос Ханги хилийн боомт хүртэл хатуу хучилттай авто зам тавих асуудлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх боломжийг судалж, танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт; | Концессын тухай хуулийн 9.4-т “Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10.1-д заасан жагсаалтад оруулах концессын зүйлийн талаарх энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлнэ” гэж заасны дагуу тухайн төслийг төр, хувийн хэвшлийн түншлэл концессын гэрээгээр хэрэгжүүлэхийн тулд тус төслийн талаарх тооцоо судалгаа нь Зам, тээврийн хөгжлийн яаман дээр хийгдэж байна. Тус тооцоо судалгааг дуусган, салбар яамнаас саналаа ирүүлсний дараа манай яамнаас тооцоо судалгааг нягтлан үзэж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шийдвэрлэнэ. | Х.Б | 0% | Холбогдох байгууллаатай хамтран шуурхай ажиллаж үр дүнтг нэмэгдүүлэх |
| | 134 | | XYI.12. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дэх улсын тусгай хэрэгцээний газраас 50 га талбайг ачаа тээврийн терминал бүхий гаалийн хяналтын бүс байгуулах зориулалтаар тусгай хэрэгцээнд авч, “Монголросцветмет” ТӨҮГ-т олгох асуудлыг холбогдох журмын дагуу судалж, танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт, гаалийн хяналтын бүс байгуулснаар гарах үр дүн, техник, эдийн | Боомтын Сэргэлтийн Үндэсний хорооны даргын үүрэг гүйцэтгэгч Д.Амарбаясгаланд Дорноговь аймгийн Замын-Үүд боомтод “Ачаа тээврийн терминал бүхий гаалийн хяналтын бүс” байгуулах 50 га газар ашиглуулах асуудал болон холбогдох зөвшөөрөл дүгнэлт гаргахад зохих арга хэмжээ авч ажиллах талаар Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01/1161 тоот албан бичиг хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 9-ний 54 дүгээр хуралдааны “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362 дугаар тогтоолын хүрээнд гаргасан тэмдэглэлийн 13 дугаар заалтад Хилийн Замын-Үүд боомтод “Монголросцветмет” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн хамтран ашиглах ачаа тээврийн терминал бүхий гаалийн хяналтын бүс байгуулах асуудлыг судлан танилцуулахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | засгийн үндэслэлийг танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гаалийн ерөнхий газар (Б.Асралт), “Монголросцветмет” ТӨҮГ-ын захирал (Б.Мөнхбат) нарт; | | | | |
| 49 | 135 | 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 32 дугаар тэмдэглэл 2022-06-08 Дугаар 2022_32 | XY.3. . Засгийн газрын гадаад, зээл тусламжийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн талаар дараахь арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүд болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагад даалгав: 1. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, гэрээнд заасан хугацаанд төслийг үр дүнтэй хэрэгжүүлж дуусгах; 2. Төслийн худалдан авах үйл ажиллагааг төлөвлөгөөт хугацаанд нь холбогдох хууль | Шинээр хэрэгжүүлэх болон хэлэлцээрийн шатанд байгаа гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, “Шинэ сэргэлтийн бодлого”-той нийцтэй байхаар ач холбогдлоор нь эрэмбэлж дараах хөгжлийн төслүүдийг гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр хөгжлийн түншүүдтэй яриа хэлэлцээг хийж байна. Үүнд: 1. Махны үйлдвэр барих төсөл - БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл 2. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл - БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл 3. Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай ЦДШ-Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл 4. Аюулгүй, шуурхай худалдааг дэмжих уян хатан, нэгдсэн хилийн үйлчилгээ төсөл АХБ-ны хөнгөлөлттэй зээл 5 Чойр-Сайншандын 220,08 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл – ЕСБХБ. 1. Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хангуулах, төсөл, арга хэмжээг эрчимжүүлэх хүрээнд Засгийн газрын хуралдаанд нийт 16 удаа танилцуулга хийж, 61 чиглэлээр Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гарсан. Энэ хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Хөгжлийн 94 төслийн бэлэн байдлын үнэлгээг хийж, төслүүдийн ангиллыг тухай бүр шинэчлэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажилласан. Хэрэгжилт эхэлсэн 26 төслөөс бусад хөгжлийн төслийг ач холбогдол, хэрэгжих боломж, | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтоомж, төслийн баримт бичгийн хүрээнд шуурхай зохион байгуулах;  3. Төслийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, гүйцэтгэлийг зохих журмын дагуу хянан баталгаажуулж, тайлагнах, үр дүн муутай, хэрэгжилт удаашралттай төслүүд болон шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж саналаа ирүүлэх;  4. Шинээр хэрэгжүүлэх болон хэлэлцээрийн шатанд байгаа төслийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, “Шинэ сэргэлтийн бодлого”-той нийцтэй байхаар ач холбогдлоор нь эрэмбэлэх, ДНБ-д эзлэх өрийн хязгаарт нийцүүлэх;  5. Засгийн газрын гадаад, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжилтийн түвшин, хугацааны хоцрогдлоор нь ангилан, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, үр дүнг тооцож хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгагдсан салбар бүрээр гаргаж 2022 оны III улиралд багтаан Засгийн газрын | эдийн засгийн ач холбогдлоор үнэлж, эрэмбэлэн, тэргүүн ээлжид хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг тодорхойлсон. Төслүүдийн нарийвчилсан төлөвлөгөөг салбар яамдаас гаргуулан авч, эхлэх дуусах хугацаа, арга хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрээр тухай бүр шинэчилж, бэлэн байдал хангагдсан 36 төсөл байсныг 49 болгож нэмэгдүүлсэн. Шинэ сэргэлтийн бодлогод туссан 94 хөгжлийн төслийн ерөнхий танилцуулга, мэдээлэл болон 55 төсөлд ТЭЗҮ хийгдсэн, холбогдох яамдаас авч төслийн мэдээллийн бааз үүсгэж ажилласан. 2022 оны байдлаар 3 төсөл хэрэгжиж дуусаж, сэргээгдэх эрчим хүчний 5 багц төслөөс 2 төсөл хэрэгжиж дуусаж, 2 төсөл эхлэхээр бэлтгэл ажил хангагдаж, 1 төсөл судалгааны ажил нь эхлэсэн бол энэ онд багтан төмөр замын 4 төсөл хэрэгжсэн. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд. | | | | |
| 50 | 136 | 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34 | XII.1.3. Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, 2022 оны 7 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд. | Хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүн, журмын төслийг шинэчлэн боловсруулж, “Зөвлөлийн бүрэлдэхүүн, журам батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал авахаар Засгийн газрын гишүүд болон Шүүхийн ерөнхий зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 2022 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 01/819 тоот албан бичгээр хүргүүлж, 16 сайд, 3 байгууллагын саналыг тусгаж батлуулахад бэлэн болгосон. | 70% | 30% | |
| | 137 | | XII.8. . Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, хүн амын хэт төвлөрлийг сааруулах төлөвлөгөөний талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд “Хот, хөдөөгийн сэргэлтийн үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийг сааруулах, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төслийг | Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын дэмжлэгтэйгээр "Дотоодын шилжилт хөдөлгөөний бодлогын судалгаа"-ны ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус судалгааны үр дүнд шилжих хөдөлгөөнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох, шилжин ирсэн, шилжин явсан иргэдийн хоорондын хамаарал, шилжилт хөдөлгөөн ба орон зайн шинжилгээ, Монгол Улсын дотоодын шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдлын талаар судалгаа хийсэн. НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Канад улсын Засгийн газрын MERIT төслийн дэмжлэгтэйгээр Эдийн засаг хөгжлийн яам, аймгийн Засаг даргын Тамгын газраас хамтран “Тогтвортой хөгжил-Шинэ сэргэлтийн бодлого Дундговь" хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт “Хот, хөдөөгийн сэргэлтийн үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийг сааруулах, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулахад чиглэсэн арга | 70% | 30% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | боловсруулан зохих журмын дагуу Улсын Их Хурлаар батлуулж, хэрэгжүүлэх талаар зохих арга хэмжээ авахыг Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгав; | хэмжээний саналыг танилцуулж орон нутгийн иргэдээс санал авсан. | | | |
| | 138 | | XII.9.2. Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэд Хуурай боомтын асуудал хариуцсан нэгж байгуулахтай холбогдуулан Ерөнхий сайдын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 104 дүгээр захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, олон улсын хуурай боомт байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлд Хуурай боомтын боомтын асуудал хариуцсан нэгж байгуулахтай холбогдуулан Ерөнхий Сайдын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 104 дүгээр захирамжаар байгуулсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, олон улсын хуурай боомт байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж танилцуулахыг даалгасны дагуу холбогдох яам, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод тус ажлын хэсэгт оруулах төлөөллийн нэр ирүүлэхийг хүссэн албан тоотыг хүргүүлж “Ажлын хэсэг байгуулах тухай” Ерөнхий сайдын захирамжийн төслийг боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 01/1636 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын тухай хуулийн 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргатай байхаар хуульчлагдсан тул хуурай боомтын асуудлыг тус сайд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэнэ. Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн болно. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 139 | | XII.12. . “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Замын-Үүд-Алтанбулаг чиглэлийн олон улсын транзит хурдны авто зам барих, хилийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох төслийн хэрэгжилтийн явцын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Арцсуурь, Ханх, Бага-Илэнх, Сүмбэр, Баянхошуу боомт чиглэлийн авто замыг барих төслийн хөрөнгийн эх үүсвэрийн талаар судалж, саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав; | Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасан байх тул хасуулах саналтай | Х.Б | Х.Б | |
| | 140 | | XII.14. . “Шинэ Зуунмод” хот байгуулах, “Залуус 1” орон сууцны хороолол барих төслийн талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлэх Хөшигийн хөндийд эдийн засгийн бүс байгуулах, “Залуус 1” орон сууцны хороолол барих, “Шинэ Зуунмод” хотын бүтээн | Эдийн засаг, хөгжлийн яамнаас боловсруулж байгаа "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын төсөлд нийслэл Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрлийг сааруулах, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах чиглэлээр дараах арга хэмжээг тусгаад байна. Үүнд: 1.Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, орон нутагт байгуулах 2. Нийслэлийн баримжаатай хотыг шинээр байгуулах 3. Эдийн засгийн макро, микро өсөлтийн төвүүдийг хөгжүүлэх 4. Аж үйлдвэрийн салбаруудыг орон нутагт кластераар хөгжүүлэх 5.Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд урамшуулал, дэмжлэг үзүүлэх 6. Орон | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулалтын болон төрийн захиргааны зарим байгууллагын нэгдсэн байрыг Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх Хөшигийн хөндийд байгуулах арга хэмжээний санхүүжилт, эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх талаар судалж, тодорхой санал боловсруулан Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Наранцогт нарт даалгав. | нутгийн инженерийн шугам сүлжээг сайжруулах гэх зэрэг арга хэмжээг тусгасан | | | |
| 51 | 141 | 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдөр 35 дугаар тэмдэглэл 2022-06-29 Дугаар 2022_35 | XXYII.4.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын боомтын сэргэлтийн хүрээнд Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 км төмөр замын төслийг эхлүүлэх, Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх 159.5 км хатуу хучилттай авто зам барих, Арцсуурь хилийн боомтын зэрэглэлийг нэмэгдүүлэх талаар судалж танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт; | Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгасан тул хасуулах саналтай. | Х.Б | Х.Б | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | 142 | 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2022-07-05 Дугаар 2022_36 | XX.9. . “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт тусгасан логистикийн төвийн байршлын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан уг асуудлыг хамтран боловсруулж Засгийн газрын хуралдаанаар дахин танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав. | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэл боловсруулах ажлын хүрээнд бүс нутгийн онцлог, эдийн засгийн нөөц, байгаль орчин, нийгэм, дэд бүтцийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, орон нутгийн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх хөгжлийн стратегийн 69 төвийг тодорхойлсон. Мөн ЗТХЯ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн арга хэмжээнд ЭЗХЯ-ны зүгээс “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах тогтолцоо, шийдэл” судалгааны үр дүнд тодорхойлогдсон ХАА-н логистик, төвийг 45 байршилд байгуулах саналыг хүргүүлсэн. Аймаг орон нутгаас логистик төвийн байршилтай холбоотой саналыг авч нэгтгэсэн. Уг Монгол Улсын тээвэр логистикийн төвийн байршлыг Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд тусгаж батлуулна. “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 282 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт нүүрс болон бусад ачаа ачих, буулгах терминал, логистикийн төв байгуулах зориулалтаар 98.5 га газрыг Улсын тусгай хэрэгцээнд авч, газрын хилийн заагийн эргэлтийн цэгүүдийг солбицол, талбайн хэмжээг баталсан. | 70% | 70% | |
| 53 | 143 | 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдөр 38 дугаар тэмдэглэл 2022-07-27 Дугаар 2022_38 | Ү.2. Боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг олон улсын чиг хандлага, шаардлагад нийцүүлэх, хөгжүүлэх асуудлыг судалж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвийн төсөлд үе шаттай жил бүр тусгаж ажиллахыг Сангийн | "Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн хурлаар Хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөлт чиглэлээр танилцуулга хийсэн. Хилийн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөлтийг хөрш орнуудын бодлоготой уялдуулан боловсруулах ажлын хүрээнд БНХАУ-ын 14-р 5 жилийн төлөвлөгөө болон ОХУ-ын урт хугацааны бодлогын баримт бичгүүдийг судалж, боомтын бүтээн байгуулалтын орон зайн төлөвлөлтийг харгалзан үзэх, боомтуудыг төрөлжүүлэх чиглэлээр | 100% | 100% | Хяналтаас хасуулах |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт даалгав. | нь ангилан эрэмбэлэх, боомтыг эдийн засгийн эргэлтэд оруулах хууль эрх зүйн орчныг сайжруулах “Хилийн боомтын тухай” хуулийг сэргээх, боомтын нэгдсэн удирдлага бий болгох зэрэг саналуудыг танилцуулсан. Үүнтэй уялдуулан Засгийн газрын хуралдааны 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 40 дүгээр тэмдэглэлээр зарим сайдад холбогдох үүрэг даалгавар өгөгдсөн. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Хилийн боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа орон зайн төлөвлөлтийг сайтар зохион байгуулах, хөрш орнуудын боомтын бодлого, төлөвлөлттэй уялдуулах бодлого баримталж, боомтуудыг импорт, экспортын нэвтрүүлэх хүчин чадал, төрлөөр нь эрэмбэлэх, боомтын асуудал хариуцсан байгууллагын бүтцийн санал боловсруулах зэрэг судалгааны ажил хийж гүйцэтгэсэн. Азийн хөгжлийн банктай хамтран “Монгол Улсад ухаалаг хил боомтыг хөгжүүлэх нь” дугуй ширээний уулзалтыг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Боомтын төлөвлөгөө, зураг төсөл, бүтээн байгуулалтын ажлыг бусад ажилтай уялдуулан авч үзэх чиглэлээр ажиллаж зарим мэдээллийг чиг үүрэг шилжсэнтэй холбогдуулан Боомтын сэргэлтийн үндэсний хороо, Хилийн боомтын захиргаанд шилжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Боомтын бүтээн байгуулалтад шаардлагатай төслийг боловсруулж санхүүжилтийг 2023 оны төсөвт тусгасан. | | | |
| 54 | 144 | 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр 40 дүгээр тэмдэглэл 2022-08-10 | XIII.3.1. Хилийн боомтын бүс орчмын улсын хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай газар дахь газар олголт, ашиглалтын мэдээллийг нэгтгэн судалж, | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 03/871 тоот албан бичгээр Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас хилийн боомт орчмын 15км*15км радиуст хамаарах кадастрын зургийн өргөтгөл бүхий файлыг гаргуулж авсан. Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дугаар 2022_40 | авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт; | оны 08 дугаар сарын 10-ны өдрийн 03/854 тоот албан бичгээр чөлөөт бүс, хилийн боомтуудын орчимд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36.1-д заасан гэрээ байгуулсан иргэд, ААН, байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. Тус мэдээлэлд үндэслэн боомтын үндсэн байгууламжийн бүтээн байгуулалтыг 3км*3км радиуст Хилийн боомтын бүс орчмын улсын хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай газар дахь газар олголт, ашиглалтын мэдээллийг нэгтгэн боловсруулж МУ-ын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад 2022 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр танилцуулсан. | | | |
| 55 | 145 | 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2022-08-17 Дугаар 2022_41 | YIII.5.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл болон бодлогын баримт бичгийн улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сангийн ажлын явцын талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд даалгав. | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсантай холбоотойгоор Үндэсний хөгжлийн газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А-41 дүгээр тушаалаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”-ыг шинэчлэн баталсан. Эдийн засаг, хөгжлийн яам 2022 онд шинээр байгуулагдсантай холбоотойгоор энэхүү Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн системийн хөгжүүлэлтийг хийж байна. Тус мэдээллийн системийн бүтэц нь: 1.Орон нутгийн хөгжлийн индекс /ldi.nda.gov.mn/; 2.Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн систем /industry4.nda.gov.mn/; 3.Судалгаа шинжилгээний мэдээллийн систем /development.gov.mn/; 4.Төсөл хөтөлбөрийн мэдээллийн систем /development.gov.mn/; 5.Бодлогын баримт бичгийн мэдээллийн систем /development.gov.mn/ зэрэг болно. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | 146 | 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | IX.1.3. “Наадамчдын өргөн чөлөө”, эсхүл “Энхтайваны өргөн чөлөө”-ний авто замд нийтийн тээврийн хэрэгслийн “зорчих хэсгийн тусгайлсан эгнээ”-г барьж байгуулах төслийг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлд хамруулах санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Азийн хөгжлийн банкны 50.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагыг сайжруулах төсөл”-ийг 2023-2024 онд хэрэгжүүлж эхлэх талаар АХБ-тай холбогдох яриа хэлэлцээг хийж байгаа ба төслийн бэлтгэл ажил хангах, нарийвчилсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах арга хэмжээг АХБ-ны “Жижиг зардлыг санхүүжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. “Жижиг зардлыг санхүүжүүлэх хөтөлбөр”-ийн зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн, УИХ-ын ТБХ-ны 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн, ЭЗБХ-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн, АБГББХ-ны 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцүүлж, 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Сангийн сайд гарын үсэг зурсан. Тус хөтөлбөрт нь томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгардаг бэрхшээлийг хөнгөвчлөх зорилгоор бэлтгэл ажлыг хангах, нарийвчилсан зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), судалгааг боловсруулах, Засгийн газрын төсөл хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх, шинэ технологи, стандарт, менежментийн арга барилыг нэвтрүүлэх зорилготой. | 70% | 70% | |
| 57 | 147 | 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2022-10-05 Дугаар 2022_48 | XII.1.2. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 2.1. Эрхлэх асуудлын хүрээнд стандарт, техникийн зохицуулалтын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; 2.2. “Үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 235 дугаар тогтоолын хавсралтаар шинээр болон шинэчлэн батлах техникийн зохицуулалтын жагсаалтыг баталсан. Энэхүү жагсаалтад Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах стандарт, техникийн зохицуулалт байхгүй боловч, Ерөнхий сайдын 2022 оны 159 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт хариуцсан чиглэлээр дэмжлэг үзүүлэхээр холбогдох албан хаагчийг томилон, мэдээлэл өгч хамтран ажиллаж байна. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тухай" Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг дүгнэж, салбарын шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг 2022 онд багтаан боловсруулж, батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд; | | | | |
| | 148 | | XII.3.2.2. Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмыг боловсруулж, 2022 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт; | Зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Бүгд найрамдах Сингапур улсын дэлхийд нэр хүндтэй зөвшөөрлийн цахим сангийн үйл ажиллагаа, цахим хөгжүүлэлтийг судалж, монголын онцлогт тохируулан нэвтрүүлэх зорилгоор УИХ-ын гишүүн Х.Ганхуяг, Ч.Ундрам, Б.Пүрэвдорж нараар ахлуулсан ажлын хэсэг ажилласан бөгөөд тус ажлын хэсгээс гарсан санал, Сингапур улсын туршлагаас зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмын төсөлд тусган боловсруулсан. Төрийн нийтийн өмч буюу байгалийн баялгийг ашиглахтай холбоотой зохицуулалтууд, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох 248 зөвшөөрөл, иргэн болон өрхийн мөн нэг удаагийн 114 энгийн зөвшөөрлийг кодолсон. | 70% | 70% | |
| 58 | 149 | 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл | YI.3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг хадгалах стандартад нийцсэн агуулах, сав барьж байгуулах санхүүжилтийн эх үүсвэрийн | Засгийн газрын гэрээ байгуулах эрх олгох тухай 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 119 дугаар тогтоол гарч, 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр "Нэйшнл трейдинг энд транспорт групп" ХХК-тай "Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл"-ийн | 70% | 30% | газрын хуралдаанд танилцуулах |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022-10-19 Дугаар 2022_50 | асуудлыг судалж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгав. | “Барих-өмчлөх-ашиглах” төрлийн концессын гэрээг байгуулсан байна. Гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөл хангагдаагүй тул 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр нэмэлт гэрээг байгуулан хугацааг сунгасан ч гэрээ хүчин төгөлдөр болоогүй. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 01/2498 тоот албан бичгээр тус төслийн концессын гэрээг дүгнэж, холбогдох арга хэмжээг авах, мөн уг гэрээний хугацааг дахин сунгахгүй байх талаар хүсэлт ирүүлсний дагуу концесс эзэмшигчид 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр “Нэмэлт гэрээ”-г байгуулах боломжгүй тухай 03/1319 дугаар албан бичгийг хүргүүлсэн. | | | |
| 59 | 150 | 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр 52 дугаар тэмдэглэл 2022-10-26 Дугаар 2022_52 | X.1.3. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн эдийн засгийн тооцоо, судалгаа, нарийвчилсан тооцоолол, өгөөж, үр ашгийн асуудлыг судалж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт; | Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн EPC-2, EPC-3-ийн эдийн засгийн тооцоо, судалгаа болон Хөгжлийн банкны зээлийн асуудлаар Эдийн засаг, хөгжлийн сайд 2022 оны 9 дүгээр сарын 27-ны засгийн газрын хуралдаанд "Шинэ сэргэлт бодлого"-ын төслийн хэрэгжилтийн явцтай хамт танилцуулсан. | 70% | 70% | |
| 60 | 151 | 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр 54 дүгээр тэмдэглэл 2022-11-09 Дугаар 2022_54 | III.3. Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолоор баталсан холбогдох Үндэсний хороодын ажлыг идэвхжүүлж, удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Эдийн | Тус тогтоолоор дараах үндэсний хороодын ажлын хэсэгт дэмжлэг үзүүлж ажилласан байна. Үүнд: “Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн”- гишүүнээр Төрийн нарийн бичгийн дарга Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүн” - гишүүнээр Эдийн засаг, хөгжлийн сайд, “Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн” -гишүүнээр Эдийн засаг, хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын бүрэлдэхүүн” - гишүүнээр Эдийн засаг, хөгжлийн | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгав. | сайд, "Усны үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн" - гишүүнээр Эдийн засаг, хөгжлийн сайд, "Уур амьсгалын үндэсний хорооны бүрэлдэхүүн"-гишүүнээр Эдийн засаг, хөгжлийн сайд, "Химийн хорт болон аюултай бодисын бодлого, зохицуулалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн" - гишүүнээр Төрийн нарийн бичгийн дарга "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүн"-гишүүнээр Төрийн нарийн бичгийн дарга "Гаалийн тарифын зөвлөлийн бүрэлдэхүүн" - орлогч даргаар Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, "Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн" - гишүүнээр Төрийн нарийн бичгийн дарга, "Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн" - гишүүнээр Төрийн нарийн бичгийн дарга, "Цөмийн энергийн комиссын бүрэлдэхүүн" - гишүүнээр Төрийн нарийн бичгийн дарга, "Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн"- гишүүнээр Эдийн засаг хөгжлийн дэд сайд тус тус ажиллаж байгаа бөгөөд удирдлагуудыг холбогдох мэдээллээр хангаж ажилласан. | | | |
| | 152 | | IY.2. Монгол Улсаас дээд, өндөр түвшинд гадаад улсад хэрэгжүүлэх айлчлал болон гадаад улсаас дээд, өндөр түвшинд хүлээн авах айлчлалын үеэр тухайн гадаад улстай хамтран хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар хэлэлцэхэд Монгол Улсын хөгжлийн бодлогын хүрээнд нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эдийн засаг, | ХБНГУ: 2022 оны 10 дугаар сарын 03-нд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны Парламентын Төрийн нарийн бичгийн дарга Н. Аннений Монгол Улс дахь албан ёсны айлчлалын үеэр Монгол Улс, ХБНГУ-ын харилцааг Иж бүрэн түншлэлээс Стратегийн түншлэлд хүргэх талаар зарчмын хувьд тохиролцсон. Япон Улс: 2022 оны 11-р сарын 29-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Японы Улсын Ерөнхий сайд Ф.Кишида нар хэлэлцээ хийж, "Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай Стратегийн түншлэл"-ийг байгуулан, ирэх 10 жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт гарын үсэг зурсан. ОХУ: 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Москва | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгав. | хотноо болсон Худалдаа, эдийн засаг, техник, шинжлэх ухааны хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын 24 дүгээр хуралдааны үеэр Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан байгалийн хий нийлүүлэх хоолой барих төсөлд гурван талын үйл ажиллагааг зохицуулж, тус байгалийн хийн хоолойг барих төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сонирхсон компанийн оролцоотой гурван талын төрийн байгууллага хоорондын ажлын хэсгийг байгуулах чиглэлээр орос, хятадын талтай ажиллах, ДЦС3-ыг шинэчлэх тухай Монгол, Оросын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулж, түүнийг тохирох чиглэлээр ажиллах, мөн Эгийн голын усан цахилгаан станцын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн дүгнэлтийг оросын талд танилцуулж, төслийг урагшлуулах чиглэлээр ажиллахаар тохиролцсон.  БНХАУ: Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2022 оны 11 дүгээр сарын 27- 28-ны өдрүүдэд БНХАУ-д хийсэн төрийн айлчлал үеэр Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар дараах томоохон 2 хөтөлбөрийг Хятадын талтай байгуулсан.  Дунд хугацааны хөтөлбөрийн хувьд Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны боломж болон тулгарах сорилт, хөгжлийн чиглэл, тэргүүлэх чиглэл зэрэг арга хэмжээнүүдийг тусгасан. | | | |
| | 153 | | ҮIII.2. Дулааны III цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг Оросын Холбооны Улсын Засгийн газрын экспортын зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх зээл, түүний нөхцөлийн талаарх хүсэлтийг холбогдох журмын | “Дулааны III цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийг Оросын Холбооны Улсын Засгийн газрын экспортын зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх зээл, түүний нөхцөлийн талаарх хүсэлтийг холбогдох журмын дагуу ОХУ-ын Сангийн яаманд зээлийн хүсэлтийг уламжилж, 2022 онд багтаан шийдвэрлэхээр ОХУ-тай тохиролцсон. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дагуу 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө ОХУ-ын Сангийн яаманд хүргүүлэхийг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгав. | | | | |
| | 154 | | Х.8.7. Төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ашигт малтмалыг худалдах, экспортлох, тээвэрлэх гэрээ, гэрээний нөхцөлийг судалж, дүнг 2022 онд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар нарт; | “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2017-2022 оны 171 гэрээ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2016-2022 оны 27 гэрээ, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хөгжлүүдийг нийгэм, эдийн засгийн ач холбогдлоор эрэмбэлж, 2023 оноос үе шаттай хэрэгжиж эхлэх болон 2023, 2024 онд хэрэгжиж дуусгах төслүүд, хөгжлийн төслийн жагсаалтад өөрчлөлт оруулах төслүүдийн саналын талаар Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын хуралдаанд 2022 оны 12 дугаар сарын 24-ний өдөр танилцуулга хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Монголросцветвет” ТӨҮГ-ын 2022 оны 18 гэрээ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн 2022 оны 6 гэрээ, нийт 222 гэрээг хүлээн авч, гэрээний нөхцөл, нэгж үнэ, хэмжээг гэрээ тус бүрээр гаргаж, гэрээ байгуулах үеийн зах зээлийн үнэтэй харьцуулалт хийсэн. | 100% | 100% | |
| | 155 | | Х.11.2. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг байгууллагын үйл ажиллагаанд уялдуулан зохион байгуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллахыг зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг харьяалах | “Зөрчлийн бүртгэлийн нэгдсэн систем”-ийг боловсруулан, зөрчлийн хэрэг шалгах, шийдвэрлэх, хянах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд тус системийг үе шаттайгаар нэвтрүүлэх ба “Зөрчлийн бүртгэлийн нэгдсэн систем”-ийг харьяа байгууллага буюу Чөлөөт бүсийн захирагч нарт 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нэвтрүүлэхээр даалгаад байна. Мөн бусад зөрчлийн хэрэг шалгах шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох эрхий бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байгаа | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсвийн ерөнхийлөн захирагч нарт; | болно. Холбогдох сургалтуудыг зохион байгуулах ажил хийгдэж байна. | | | |
| | 156 | | X.13. . Төмөр замын бүтээн байгуулалт, шинэчлэлтийн зарим төсөлд Оросын Холбооны Улстай хамтран ажиллах талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд оролцох үеэр “Богдхан” төмөр замын бүтээн байгуулалт болон “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр замын засвар, шинэчлэлтийн төслийг хамтран хэрэгжүүлэх талаар оросын талтай санал солилцож, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав. | 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Москва хотноо болсон Худалдаа, эдийн засаг, техник, шинжлэх ухааны хамтын ажиллагааны Монгол, Оросын ЗГ хоорондын комиссын 24 дүгээр хуралдааны үеэр төмөр замын салбарын олон асуудлыг шуурхай шийдвэрлэх шаардлагатай байгааг Оросын талд анхааруулсан. УБТЗ-аар ачаа тээвэрлэх тарифыг 2025 онд хүртэл индексжүүлэх бодлогыг цаг тухайд хэрэгжүүлэх, “Богдхан” төмөр замын төсөлд оросын тал хэрхэн оролцох шийдвэрээ хурдан гаргах, “УБТЗ” ХНН-ийн 2050 он хүртэлх хөгжлийн цогц стратегийг Монгол Улсын тээврийн тогтолцоог хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан Чойбалсан Эрээнцавын төмөр замын хэсгийг шинэчлэх, Сайншанд-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг шинэчлэх, Сайншанд, Зүүнбаян өртөөг өргөтгөх ажлыг хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Засгийн газар хоорондын комиссын хуралдааны дүнг 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. | 100% | 100% | |
| 61 | 157 | 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр 56 дугаар | I.. ““Цагааннуур” чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг | 1.Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Цагааннуур чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх тухай” тогтоол батлагдсан. 2. Ерөнхий сайдын 2022 оны 6 | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тэмдэглэл 2022-11-23 Дугаар 2022_56 | хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2. Чөлөөт бүсийг хөгжүүлэх асуудалд анхаарч ажиллах, “Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” Ерөнхий сайдын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 4 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгав. | дугаар сарын 28-ны өдрийн 96 дугаар захирамж, “Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 04 тоот албан даалгавар гарсан. Ажлын хэсгийн анхны хурлыг 2022 оын 7 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулж Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөлт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөөг батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу холбогдох байгууллагуудаас Ажлын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж удирдлагуудад цахимаар хүргүүлсэн. Уг ажлын хүрээнд “Эдийн засаг, хөгжлийн яамны захиалгаар “Алтанбулаг” чөлөөт бүсийн цахилгаан, эрчим хүчний өргөтгөлийн ажлын 35/10 кВ 2х4000 кВа дэд станцын барилга угсралтын ажил, 10кв-н хуваарилах байгууламж, 2х630 кВа чадалтай хаалтай дэд өртөөний барилга угсралтын ажлыг “Улаанбаатар электромонтаж” ХХК-тай 15,296,668,018 (арван таван тэрбум хоёр зуун ерэн зургаан сая зургаан зуун найман мянга арван найм) төгрөгийн төсөвт ажлыг гүйцэтгүүлэхээр 2022 оны 3 сарын 30-ны өдөр ЭЗХЯ /63 гэрээ байгуулсан. 2022 онд улсын төсвөөс 200,000,000 ( хоёр зуун сая) төгрөгийн санхүүжилт олгогдоод байна. 2022 онд хийгдсэн барилга угсралтын ажлын хүрээнд “Алтанбулаг” чөлөөт бүсийн 35/10Кв-ын 2*4000 чадалтай дэд станцын барилгын суурь ухаж,ул бетон цутгах, суурь хийх, барилгын өрлөгийн ажил 100%-тай хийгдсэн , бүс бетон цутгасан, хучилтын хавтан тавигдсан байна. РП-2 дээр суурийн нүх ухаж, ул бетон цутгасан,суурийн ажил хийгдсэн, барилгын өрлөгийн ажил 20%-тай байна. ХТП-7 дээр суурь ухсан, ул бетон цутгасан, суурь хийгдсэн. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ХТП-8,6,5,4,3,2,1 дээр суурийн нүх ухсан, ул бетон цутгасан 1%-ын гүйцэтгэлтэй ажлууд хийгдсэн байна. | | | |
| | 158 | | II.. “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов. 2. Монгол Улсад сүүлийн 30 жилд хөрөнгө оруулсан гадаадын иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой гомдлыг судлан танилцуулах, шаардлагатай тохиолдолд Ажлын хэсэг байгуулан ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт даалгав. | “Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 413 дугаар тогтоолын биелэлтийг иргүүлэх тухай албан бичгийг холбогдох яамдад хүргүүлсэн.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас | 30% | 30% | |
| | 159 | | XII.2. Япон Улсын Токио хотод 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулах Монгол, Японы төр, хувийн хэвшлийн 10 дугаар зөвлөлдөх уулзалтад оролцох монголын талын төлөөлөгчдийн баримтлах удирдамжийг хэлэлцээд зөвшөөрөв. 2. Уг зөвлөлдөх уулзалтад оролцох монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлахыг Эдийн засаг, | Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Япон Улсад хийсэн албан ёсны төрийн айлчлал 2022 оны 11 дүгээр сарын 29-өөс 12 дугаар сарын 02-ны өдрийн хооронд зохион байгуулагдаж, 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Японы төр, хувийн хэвшлийн 10-р зөвлөлдөх уулзалтыг монголын талаас Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч О.Амартүвшин нар нээж үг хэлсэн. Зөвлөлдөх уулзалтад Монголын талаас Моннис групп, Таванбогд групп, Мобиком корпорац зэрэг 36 аж ахуйн нэгжийн 60 гаруй төлөөлөгч, Японы талаас | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжлийн сайд бөгөөд тус зөвлөлдөх уулзалтын Монголын хэсгийн дарга Ч.Хүрэлбаатарт даалгав. | Иточу, Марубени зэрэг Мицүбиши зэрэг компаниудын 150 төлөөлөгч оролцов. Зөвлөлдөх уулзалтын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг баталсан. | | | |
| 62 | 160 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.1.2. Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа болон гадаад томилолтыг хориглох, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, тэдгээрийг томилох эрх бүхий этгээдэд; | Эдийн засаг, хөгжлийн яамны 2022 оны төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааныг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг үндэслэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулсан болно. Шаардлагагүй худалдан авалт болон гадаад, дотоод томилолтыг хориглож, төсвийн хөрөнгөөр ямар нэгэн баяр, ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй бөгөөд батлагдсан орон тоондоо багтаан урсгал зардлыг хэмнэсэн. | 100% | 100% | |
| | 161 | | XXI.1. . Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд бүтцийн өөрчлөлт хийх, засаглалыг сайжруулах талаар санал боловсруулж танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Эдийн засаг, хөгжлийн сайд | Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдэд бүтцийн өөрчлөлт хийх, засаглалыг сайжруулах чиглэлээр Эрдэнэс Тавантолгой болон Монголросцветмет, Эрдэнэс Монгол ТӨҮГ зэрэг төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд бодлогын санал болон компанийн дүрэмд санал өгч ажилласан. | 70% | 70% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт; | | | | |
| | 162 | | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | Эдийн засаг, хөгжлийн яам нь төрийн байгууллагуудтай албан бичиг солилцооны дундын систем ашиглан / docx.gov.mn/ цахим хэлбэрээр албан бичиг солилцон ажиллаж байна. Майкрософт 360 програмыг дотоод үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэрэглэж хэвшсэн бөгөөд цаас дамжуулж үр ашиггүй зардлаас бүрэн татгалзсан. Тус системийг цаашид хөгжүүлж Төрийн бусад байгууллагууд хоорондын уялдаа холбоо /тэр дундаа харьяа байгууллагууд/-г сайжруулахад, төрийн үйлчилгээг түргэн шуурхай явуулахад анхаарч байна. | 100% | 100% | |
| 63 | 163 | 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2022-12-21 Дугаар 2022_62 | XYI.1. . “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийн явцын талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хөгжлийн төслүүдийн судалгаа, тооцооллыг хийж, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын | Шинэ сэргэлтийн бодлогын хөгжлүүдийг нийгэм, эдийн засгийн ач холбогдлоор эрэмбэлж, 2023 оноос үе шаттай хэрэгжиж эхлэх болон 2023, 2024 онд хэрэгжиж дуусах төслүүд, хөгжлийн төслийн жагсаалтад өөрчлөлт оруулах төслүүдийн саналын талаар Монгол Улсын Ерөнхий сайд болон Засгийн газрын хуралдаанд 2022 оны 12 дугаар сарын 24-ний өдөр танилцуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. | 100% | 100% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтаас хасах шаардлагатай төслийн саналаа тодорхой үндэслэл, судалгаатай боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав. | | | | |
| | 164 | | XYI.5. . Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын хүрээнд Олон улсын санхүүгийн төв байгуулах эрх зүйн орчны талаар Монгол Улсын Шадар сайд, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын үндэсний хорооны дарга С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Олон улсын санхүүгийн төв байгуулах тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Монгол Улсын Шадар сайд, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын үндэсний хорооны дарга С.Амарсайхан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав. | Хөшигийн хөндийн ЭЗЧБ: 1.Барилга хот байгуулалтын яам, Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨУҮГ-тай байгуулсан №2022/23 тоот гэрээний дагуу Хөшигийн хөндийн Эдийн засгийн чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн ажлын эцсийн тайланг танилцуулсан. 2. Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн дэд бүтцийн зураг, төслийн ажлыг яаралтай эхлүүлэх, хэсэгчилсэн дэд бүтцийг уламжлалт болон орчин үеийн ухаалаг технологитой хослуулах шийдлийг боловсруулж, танилцуулсан. 3. Монгол Улсын шадар сайдын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ЗГ-2/711 тоот албан бичгээр Олон улсын санхүүгийн төвийн тухай хуулийн төслийн ирүүлсэн бөгөөд дотоод нэгжүүдээс санал авч нэгтгээд байна. Мөн тус хуулийн төслийн үзэл баримтлалыг судлан санал боловсруулж байна. Батлуулах үзэл баримтлалын хувь нь Эдийн засаг, хөгжлийн яаманд ирээгүй байгаа бөгөөд төсөлтэй нь танилцан батлах явцад бэлдэж байна. | 70% | 70% | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 64 | 165 | Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_4 | 5. Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхланд: 1.1. Замын-Үүд чөлөөт бүс рүү салбар төмөр зам барих, өргөтгөлийн ажлын “ТЭЗҮ-зураг төсөв боловсруулах-Барих-Ашиглах-Шилжүүлэх” төрлөөр “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нэмэх асуудлыг судалж танилцуулах; 1.2. “Замын-Үүд” чөлөөт бүсийн одоо байгаа гүний орц, гарцаас холболтын байгууламж хүртэлх тусгай зориулалтын (хүнд даац) авто замыг барих ажлыг “ТЭЗҮ-зураг төсөв боловсруулах-Барих-Ашиглах-Шилжүүлэх” төрлөөр “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нэмэх асуудлыг судалж танилцуулах; 1.3. “Замын-Үүд” чөлөөт бүсийн дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуургын 2 дугаар ээлжийн ажлыг “Барих-Ашиглах-Шилжүүлэх” төрлөөр “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулсныг “Барих-түрээслэх-шилжүүлэх” төрөл болгон өөрчлөх асуудлыг судалж танилцуулах; 1.4. “Замын-Үүд” чөлөөт бүсийн ээлжийн авто зам, гэрэлтүүлэг, | Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газрын дарга Х.Эрдэнэбулган нар 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Замын-Үүд чөлөөт бүсийн холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, тогтоолын 1.1-1.2-т заасан төслүүдийг Замын-Үүд чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдаж буй эсэхийг анхаарах, зардал, үр ашгийн урьдчилсан тооцооллыг үндэслэл, судалгаатай хийж дахин ирүүлэхийг, 1.3-1.5-д заасан төслүүдийг Концессын тухай хуулийн 6.1.1, Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолын 1.5 дахь хэсэг /шинээр концессын гэрээний дагуу хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх үүрэг хүлээхгүйгээр, Улсын болон орон нутгийн төсөвт төлбөрийн ачаалал үүсгэхгүйгээр концессын бусад төрлөөр хэрэгжүүлж ажиллах/-т заасны дагуу концессын “барих-түрээслэх-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх боломжгүйг тус тус мэдэгдсэн.1.6. “Зөвшөөрлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан “Чөлөөт бүсэд мөрдөх журам”, “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, “Чөлөөт бүсэд тамхи худалдаалах,түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажил Эдийн засаг, хөгжлийн сайдын А/100 тоот тушаалын дагуу Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд ААН болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан. 1.7.Чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдын зөвлөлийг шинээр байгуулахаар ажиллаж байна. | 100% | 70% | Бодит үр дүнг нэмэгдүүлэх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбооны байгууламжийн 2 дугаар ажлыг “Барих-Ашиглах-Шилжүүлэх” төрлөөр “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулсныг “Зураг төсөв боловсруулах-Барих-түрээслэх-шилжүүлэх” төрөл болгон өөрчлөх асуудлыг судалж танилцуулах; 1.5. “Замын-Үүд” чөлөөт бүсийн хилийн болон гүний гарц дахь шалган нэвтрүүлэх постын барилгын ажлыг “Барих-Ашиглах-Шилжүүлэх-түрээслэх” төрлөөр “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулсныг “Зураг төсөв боловсруулах-Барих-түрээслэх-шилжүүлэх” төрөл болгон өөрчлөх асуудлыг судалж танилцуулах; 1.6. Чөлөөт бүсийн үйл ажиллагааг зохицуулж байгаа гарсан хууль, тогтоомж, дүрэм, журмын нэгдсэн судалгааг гаргаж, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг арилгах асуудлыг судалж танилцуулах; 1.7. Чөлөөт бүсийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан Чөлөөт бүсийн хөрөнгө оруулагчдын зөвлөлийг шинэчлэн байгуулах. | Байгууллагуудаас албан тоотоор нэрсийг авч нэгтгэсэн. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 65 | 166 | Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай 2022-11-16 Дугаар 2022_16 | 1. Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт: 1.Гаалийн хяналтын талбай болон албан ажлын өрөөнүүдийг камержуулах арга хэмжээг бүрэн дуусгах; 2.Гаалийн байгууллагын үйлчилгээг цахимжуулж, хилийн боомт, гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах, барааг урьдчилан мэдүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах; 3.Гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох арга хэмжээг эрчимжүүлэх; | 1. 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/1697 дугаартай албан бичгээр Гаалийн ерөнхий газарт гаалийн бүртгэлийн системд цогц шийдлийг олж нэвтрүүлэх, бүсийн зорчигч, тээврийн нэвтрэлтийг хурдасгахад холбогдох арга хэмжээ авах тухай албан бичгийг хүргүүлсэн. 2. Чөлөөт бүсийн нэгдсэн цахим систем бий болгох судалгааг хийж, ажлын даалгавар боловсруулж санхүүжилтийн эх үүсвэрийг судалж танилцуулах ажлын хүрээнд Гаалийн деклораци олголтыг хялбаршуулах, цахимжуулах талаар дараах ажлуудыг хийлээ.Үүнд: -Шалган нэвтрүүлэхийн программыг гаалийн CAIS программтай холбож, туршилт тохируулгын ажлыг “Гэрэгэ системс” ХХК, “Аствишн”ХХК-иуд хийгээд байна. 3.Гаалийн ерөнхий газрын МТТ-өөс шалган нэвтрүүлэхийн программаас сервер татах, дэлгүүрүүдийг холбох тухайд ажлын хэсэг газар дээр нь ажиллаж эцэслэн шийдвэрлэсэн. 4. ОХУ-тай чөлөөт бүсийн чиглэлээр гадаад хамтын ажиллагаа идэвхжүүлэх, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах боломжийг судалж танилцуулах ажлын хүрээнд: Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газрын комиссын 24 дүгээр хуралдааны протоколд “Алтанбулаг” чөлөөт бүсийн саналуудыг тусган хүргүүлсэн. | 100% | 100% | |